



“УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ
“ДАЛАН-УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ,
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2025 ОН

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН
УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ТОВЧИЛСОН ҮГС

БОАЖГ	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
БОАЖЯ	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
БОМТ	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БОНЕУ	БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ
БОННУ	БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ
ХАБЭА	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ
ХЭМАБ	ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН
УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	5
1.3. ТӨСЛИЙН БАЙРШИЛ	5
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ	6
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
3.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	8
3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	8
3.3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	12
БҮЛЭГ 4. ТЖБОМТ-НИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	13
4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ	13
4.2. ТЖБОМТ-НИЙ ЗОРИЛГО, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮР ДҮН	14
4.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ	15
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
БҮЛЭГ 7. “ТЭРБУМ МОД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	28
БҮЛЭГ 8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	29
БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	30
БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АРГА ХЭМЖЭЭ	32
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АРГА ХЭМЖЭЭ	41
БҮЛЭГ 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	47
12.1. АГААРЫН ЧАНАР	51
12.2. ХӨРСНИЙ БОХИРДОЛ	55
12.3. УСНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ	59
БҮЛЭГ 13. ТЖБОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	65
БҮЛЭГ 14. АЙМАГ, СУМ, ОРОН НУТГИЙН БОЛОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	68
БҮЛЭГ 15. ТӨСЛИЙН 2025 ОНЫ БОМТ-НИЙ НИЙТ ЗАРДАЛ	70

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ОРШИЛ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Далан-Ухаа төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн ажлыг “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 4.13-т хэрэгжиж буй төслийн ТЭЗҮ, зураг төсөл, нөөц, хүчин чадал, техник, технологийг шинэчлэх тохиолдолд БОННУ-ний тайланд хийнэ гэж заасны дагуу хийж гүйцэтгэсэн. Тус ажлын үндэслэл нь Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шинжилгээ хийх журам”, БОУАӨЯ-ны шинжээчийн гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тавьсан шаардлага зэргийг үндэс болгосон ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх талаар Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10 -ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал” зэргийг баримталсан болно.

Исэлдсэн хүдрийн нөөцийг бодитой В зэрэглэлээр 25.41%-ийн дундаж агуулгатай 30.26 мян.тн хүдэрт 7.69 мян.тн төмөр, боломжтой С зэрэглэлээр 30.33%-ийн дундаж агуулгатай 225.95 мян.тн хүдэрт 68.52 мян.тн төмөр, бодитой ба боломжтой В+С зэрэглэлээр 29.75%-ийн дундаж агуулгатай 256.20 мян.тн хүдэрт 76.21 мян.тн төмөр, анхдагч хүдрийн нөөцийг бодитой В зэрэглэлээр 30.24%-ийн дундаж агуулгатай 31.0 мян.тн хүдэрт 9.37 мян.тн төмөр, боломжтой С зэрэглэлээр 31.73%-ийн дундаж агуулгатай 397.85 мян.тн хүдэрт 126.25 мян.тн төмөр, бодитой ба боломжтой В+С зэрэглэлээр 31.63%-ийн дундаж агуулгатай 428.85 мян.тн хүдэрт 135.63 мян.тн төмөр, ордын нийт исэлдсэн ба анхдагч хүдрийн нөөцийг бодитой ба боломжтой В+С зэрэглэлээр 29.43%-ийн дундаж агуулгатай 685.05 мян.тн хүдэрт 211.84 мян.тн төмөр гэж ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

АҮЭБЯ-АМГТГ- ЭБМЗ-ийн дүгнэлтээр 2024 оны 12 сарын 17-ны өдрийн т/24-27- 05 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2025 оны 01 сарын 24-ий өдрийн Т/16 тоот тушаалаар батлагдсан.

- Ил уурхайг олборлохын тулд 907.95 мян.м3 хөрс хуулалт хийж, жилд 200.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар 2 жилийн хугацаанд ашиглана.
- Далд уурхайг олборлохын тулд 236.53 мян.тн хүдэр, хүдэр дэх металлын хэмжээ 69.91 мян.тн байна. Нийт 644 м үндсэн малталт, 1813 м бэлтгэл малталт нэвтрэхээр тооцож, жилд 150.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар 2 жилийн хугацаанд ашиглана.
- Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал жилд 200.0 мян.тн байна. Уг ордын хүдрийг хуурай аргаар баяжуулан 51%-ийн агуулгатай 76.71%-ийн металл авалттай, 45.78%-ийн гарцтай, 277.25 мян.тн төмрийн баяжмал болон 40%-ийн агуулгатай, 9.0%-ийн металл авалттай, 6.8%-ийн гарцтай, 41.5 мян.тн завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр тооцсон.

Төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ. БОХТ буюу сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан. ОХШХ-т нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хугацаа ба давтамж, баримтлах стандарт, арга аргачлал болон шаардагдах зардал зэргийг тодорхойлон оруулсан.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг /БОМТ/-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

1.2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: Далан-ухаа төмрийн хүдрийн ордыг ил, далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр

Төслийн зорилго: Энэхүү төслийн зорилго нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ил, далд аргаар ашиглан олборлолт явуулж түүнийг баяжуулахад оршино.

Төслийн товч тодорхойлолт:

ЭБМЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 02-ний өдрийн хх-01-03 тоот дүгнэлт, ҮГА- ы 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Н/20 дугаар тоот тушаалаар нөөцийг баталсан.

Исэлдсэн хүдрийн нөөцийг бодитой В зэрэглэлээр 25.41%-ийн дундаж агуулгатай 30.26 мян.тн хүдэрт 7.69 мян.тн төмөр, боломжтой С зэрэглэлээр 30.33% -ийн дундаж агуулгатай 225.95 мян.тн хүдэрт 68.52 мян.тн төмөр, бодитой ба боломжтой В+С зэрэглэлээр 29.75%-ийн дундаж агуулгатай 256.20 мян.тн хүдэрт 76.21 мян.тн төмөр, анхдагч хүдрийн нөөцийг бодитой В зэрэглэлээр 30.24%-ийн дундаж агуулгатай 31.0 мян.тн хүдэрт 9.37 мян.тн төмөр, боломжтой С зэрэглэлээр 31.73%-ийн дундаж агуулгатай 397.85 мян.тн хүдэрт 126.25 мян.тн төмөр, бодитой ба боломжтой В+С зэрэглэлээр 31.63%- ийн дундаж агуулгатай 428.85 мян.тн хүдэрт 135.63 мян.тн төмөр, ордын нийт исэлдсэн ба анхдагч хүдрийн нөөцийг бодитой ба боломжтой В+С зэрэглэлээр 29.43%-ийн дундаж агуулгатай 685.05 мян.тн хүдэрт 211.84 мян.тн төмөр гэж ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

Хүснэгт 1

Аж ахуйн нэгжийн нэр	“Ундармал хүдэр” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011604121
Регистрийн дугаар	6072402
Хаяг	email: undarmalkhuder@gmail.com, Утас: 88886702

1.3. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

“Ундармал хүдэр” ХХК нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Далан-Ухаа нэртэй 1422.95 га талбай бүхий ашигт малтмал ашиглах MV- 022826 тоот

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

тусгай зөвшөөрлийг 2024 оны 10 дугаар сарын 14-нд 30 жилийн хугацаатайгаар эзэмшиж эхэлсэн.


Талбайн хэмжээ: 1422.95 га

Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-49-62

Хүснэгт 2. MV-022826 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн

№	Уртраг	Өргөрөг
1	108° 47' 58.630"	46° 7' 3.660"
2	108° 49' 59.645"	46° 7' 4.111"
3	108° 50' 1.620"	46° 4' 27.650"
4	108° 47' 21.620"	46° 4' 27.660"
5	108° 47' 21.630"	46° 5' 31.660"
6	108° 47' 58.630"	46° 5' 31.660"

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

хавцал ам үүсгэсэн тохиолдол бий/ оршдог. Нутаг дэвсгэрийн өмнөд болон зүүн хойд хэсгүүдээр багахан хэмжээний талбайд Цагаан цавын свитын базальтын тархалт бүхий багавтар дов толгодлог гадаргуу тохиолдох ба эдгээр нь жижиг гуу жалга, хуурай сайруудаар нэлээд их хэмжээгээр хэрчигдсэн онцлогтой.

Уур амьсгалын нөхцөл

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын төв цөлөрхөг хээрийн бүсэд, хойд өргөргийн 45.550, зүүн уртрагийн 109.050-т, д.т.д 1100 м өндөрт оршино. Даланжаргалан суманд жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа, урт /жилийн 157 хоногт агаарын хоногийн дундаж температур 0.0оС-аас бага/, агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас бага, үүлшил, агаарын чийгшил багатай эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг. Даланжаргалан орчимд жилдээ 3170 орчим цаг нар гийгүүлэх бөгөөд Сайншандын нарны цацраг судлалын өртөөний мэдээгээр баримжаалбал газрын гадарга дээр 5700 Мдж/м² хэмжээний нарны эрчим хүч ирдэг байна.

Ус зүйн сүлжээ

Энэ бүс нутагт гадаргын усны жилийн дундаж нөөц 0.25 км³ байдаг нь нэн бага хэмжээ юм. Усны гадаргаас уурших ууршил 200 см/жил хүртэл байдаг бол ууршиц 80 см/жил-ээс их байна. Гадаргын усны болон хөрсний чийг багатай байдгаас уурших усны хэмжээ бага, харин уурших боломжит хэмжээ манай орны хувьд хамгийн их байдаг нутаг юм. Гадаргын урсацын жилийн дундаж хэмжээ 1 мм орчим, гадаргын түр урсацын модуль 0.003 л/с.км², гадаргын жилийн нөөцийн хувийн нэгж 0.1 мян.м³/км² тус тус байна. Олон жилийн дундаж урсацын давхраа 25 мм-ээс бага, 1 хувийн хангамж бүхий шар ус, хур борооны үерийн хамгийн их урсацын модуль тус тус 0.1 м³ /с км-ээс бага, түр урсгал бүхий гол горхины муж байна. Бэлчээрийн болон унд ахуйн усны эх үүсвэр нь газрын доорхи ус байх ба тус бүс нутагт сульфат зонхилсон эрдэсжилт ихтэй байдаг.

Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг

Хайгуулын талбай нь ботаник-газарзүйн мужлалаар говийн цөлөрхөг мужид багтана. Энд говийн хайргархаг элс, дайргархаг-элсэрхэг хөрс тархсан байх бөгөөд энэхүү хөрс нь ялзмаг багатай чийг хадгалалт муутай байдаг. Ус чийг багатай хуурай салхи ихтэй байдаг учир ургамлын бүрхэвч тачир сийрэг байдаг. Хайгуулын талбайд дээрх хөрс,

нөхцөлд зохицсон ус чийг бага шаарддаг халуунд тэсвэртэй бутлаг, дэрслэг ургамал ургана. Энэ районд хазаар өвс, чихэр өвс, цулхир, гоёо, таана, хөмүүл, хулангийн ундаа, харгана, бударгана, шаваг, загсгал, тоорой, заг, хайлаас, сухай зэрэг ургамлууд ургана. Хөмүүл, таана зэрэг сонгинолог ургамлыг хүмүүс хүнсэндээ хэрэглэнэ. Мөн загсгал, чихэр өвс, цульхир зэрэг эмийн ургамлыг эмчилгээнд ашигладаг. Элсэн манхануудад хар суль, цульхир ихээр ургадаг бөгөөд хүмүүс түүж авч хүнсэндээ ашигладаг.

Амьтны аймаг

Төслийн талбай нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Төв халхын хуурай хээрийн тойрогт багтана. Энэ нь төслийн талбай нь төв халхын хуурай хээрийн урд захад орших учир тал хээрийн амьтдаас гадна говь цөлийн амьтад тархсан байдаг. Амьтан судлаачдын бүтээлд тэмдэглэсэн зүйлүүд болон бидний ажиглалт, аман мэдээнд тулгуурлан тодорхойлвол тус талбай орчимд 78 зүйл шавж, 4 зүйл мөлхөгч, 52 зүйл шувуу, 19 зүйл хөхтөн амьтан бүртгэгдсэн байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Энэ бүлэгт төслөөс байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөх орчноор буюу газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлын аймаг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр авч үзэн тодорхойлж, тэдгээр нөлөөллийн эрчим, цар хүрээг үнэлэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан болно.

3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А/117

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

дугаар тушаалын 2 дүгээр хавсралт, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шинэчилсэн аргачлал болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 12 сарын 31-ны өдрийн А/331 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлно. Нөлөөллийн хэмжээг тодорхойлох нь тухайн хүний ойлголтоос ихээхэн хамаардаг тул ихэнх тохиолдолд байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр дараах шаардлагыг мөрдөх шаардлагатай. Нөлөөллийн хэмжээг 3 хүчин зүйлээр тодорхойлно. Нөлөөлөл тус бүрд дээр дурдсан хүчин зүйл бүр 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал.

Хүснэгт 3. Нөлөөллийг тооцох аргачлал

Хэмжээ тархалт □M□ 1, 2 ба 3	Нөлөөллийн хэмжээг тодорхойлно. □бага, дунд, их□ Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хугацааг тодорхойлно. (богино, дунд, урт хугацаа)
Хамрах хүрээ □S□ 1, 2 ба 3	Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх газар зүйн байрлал, талбай (тухайн талбай орчимд, арай өргөвтөр талбайд, нэлээд өргөн газар нутгийг хамарсан)
Давтамж/магадлал □F□ 1, 2 ба 3	Дахин давтагдах магадлал ба дахин давтагдах тоо (бага магадлалтай, өндөр магадлалтай, тохиолдол нь тодорхой)

Болзошгүй нөлөөллийг хэмжээ, хамрах хүрээ, давтамж гурвын үржвэрээр тооцно.

$M \times S \times F =$ Болзошгүй нөлөөллийн хэмжээ

Нөлөөллийн хамгийн бага хэмжээ 1 (1x1x1), хамгийн их хэмжээ нь 27 (3x3x3) байна. Нөлөөллийн хэмжээ 6-аас доош байгаа тохиолдолд үл мэдэгдэх нөлөөлөл гэж үзнэ. Дараах хүснэгтэд хэмжээ, хамрах хүрээ, давтамж гуравт үнэлгээг харгалзуулах журам, нэгдсэн үнэлгээг тооцоолох тухай журмыг харуулсан болно. Хэрвээ тухайн нөлөөлөл хуулийн зохицуулалт хийх шаардлагатай болохоор бол мэдэгдэхүйц нөлөөлөлд тооцогдоно.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 4. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур

Төрөл/үнэлгээ Шалгуур	Төрөл/үнэлгээ Шалгуур		
М: Хэмжээ, тархалт			
Түвшин -1	Түвшин -1 Бага болон богино хугацааны нөлөөлөл - энэ хоёр нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд		
Түвшин -2	Дунд зэрэг, эсвэл дунд хугацааны нөлөөлөл - Энэ хоёр нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд		
Түвшин -3	Томоохон, эсвэл урт хугацааны нөлөөлөл- Энэ хоёр нөхцөлийг аль нэгийг хангасан тохиолдолд		
Нөлөөллийн түвшин			
Бага зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд бага	Богино хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сарын хугацаа нөхөн сэргээгдэх боломжтой
Дунд зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд дунд зэрэг	Дунд хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сараас 2 жилийн хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой.
Томоохон нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд их	Урт хугацааны	Төсөл дууссанаас хойш 2 ба түүнээс жилийн хугацаанд дараа нөхөн сэргээгдэх боломжтой
S: хамрах хүрээ буюу газарзүйн тархалт			
Үнэлгээ= 1	Нөлөөлөх талбай: зөвхөн төслийн талбайн хүрээнд		
Үнэлгээ =2	Нөлөөлөх талбай: төслийн талбайгаас гадагш 500м-ийн радиуст		
Үнэлгээ =3	Нөлөөлөх талбайн: 500м-ийн радиусаас цааш талбайг хамарсан		
F: Давтамж буюу магадлал			
Үнэлгээ= 1	Бага магадлалтай- Санал болгож буй төсөлтэй ижил төслүүдийн хувьд үүсэж байсан, энэ төслийн хувьд бараг тохиолдох боломжгүй		
Үнэлгээ =2	Дунд зэргийн магадлалтай - Энэ төслийн хувьд тохиолдох боломжтой		
Үнэлгээ =3	Өндөр магадлалтай - Энэ төслийн хувьд бараг л тохиолдоно		
Нийт түвшин= $M \times S \times F$	Үнэлгээ	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээ	
Нөлөөллийн түвшин бага	<6	Бага - Тийм ч анхаарал татахуйц биш	
Нөлөөллийн түвшин дунд	6-18	Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	
Нөлөөллийн түвшин өндөр	>18	Их буюу өндөр - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	
Бууруулж болохуйц нөлөөлөл: Нөлөөлөл нь их боловч тодорхой аргыг хэрэглэснээр нөлөөллийн түвшнийг бууруулах боломжтой.			
Үр дүнтэй (зэрэг нөлөөлөл): Нөлөөлөл нь их боловч байгаль орчин, хүний хэрэглээ, хүний үнэ цэнийг сайжруулж чадна			

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, дуу чимээ, усан орчин, хөрс, ургамал үзүүлэх байдлаар нь үнэлж, үр дүнг тодорхойлов.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 5. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны хүчин зүйлс	Эрчим		Тайлбар
	M x S x F	Нөлөөллийн үнэлгээ, эрчим	
Агаарын чанарт	3x1x3	Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	<ul style="list-style-type: none"> Төслийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээнд явах машинууд олон салаа зам гаргаж газрын гадарга талхлах, тэдгээрийн хөдөлгөөнөөс агаарт тоос дэгдэх
Дуу чимээнд үзүүлэх нөлөө	1x2x2	Бага - Тийм ч анхаарал татахуйц биш	<ul style="list-style-type: none"> Төслийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс дуу шуугиан үүсэж, орчинд тархах
Газрын гадаргад үзүүлэх нөлөө	1x1x3	Бага - Тийм ч анхаарал татахуйц биш	<ul style="list-style-type: none"> Барилга угсралтын үйл ажиллагаа, машин техникийн хөдөлгөөнөөр газрын гадаргад нөлөө үзүүлнэ.
Хөрсөнд үзүүлэх нөлөө	1x2x2	Бага - Тийм ч анхаарал татахуйц биш	<ul style="list-style-type: none"> Машин техникийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсэх, газрын гадарга, хөрсөн бүрхэвчид элэгдэл, эвдрэл үүсэх Түүхий эдийн тээвэрлэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд өртөх, физик шинж чанар өөрчлөгдөх
Ургамлын бүрхэвчид үзүүлэх нөлөө	2x2x2	Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	<ul style="list-style-type: none"> Төслийн барилга байгууламж, тулгуур шон угсрах, шинэчлэх үйл ажиллагаанд ойр ормын ургамлан нөмрөг талхлагдах, устаж үгүй болох Төслийн бүхий л үйл явц, түүний хог хаягдал, зам зэрэг үйл ажиллагаанаас буй болох тоосжилт нь ургамал нөмрөг дээр бууж хуримтлагдах
Усан орчин	1x1x2	Бага - Тийм ч анхаарал татахуйц биш	<ul style="list-style-type: none"> Авто засварын газар болон авто машинаас шатахуун болон шатах тослох материал асгаран хөрсөн бүрхэвчээр дамжин гадаргын болон газрын доорх усанд нэвчих бохирдол үүсэх Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу хог хаягдал зэргийн үлдэгдэл угаагдан хөрс, газрын хэвлийг бохирдуулах улмаар гүний усыг бохирдуулах
Амьтны аймаг	3x1x3	Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	<ul style="list-style-type: none"> Засвар үйлчилгээ, барилга угсралтын үед ажиллах тээврийн хэрэгсэл, техникүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих Зэрлэг амьтдын амьдрах таатай орчинд сөргөөр нөлөөлөх, нүүдлийн замд саад хийх

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

3.3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга

Хэмжээ

Үзүүлэлт	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх
Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> ✓ Тухайн жилийн БОМТ-н БОХТ, БОХШХ-т тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж, тоос болон бусад хийн хэмжилтийг хийж, тухайн орчны агаарын бохирдолтыг хянаж байх. ✓ Төслийн бүхий л үйл ажиллагааны явцад тоосжилтыг хянах бууруулах үр ашигтай бөгөөд практик ач холбогдолтой үйл ажиллагааны журмыг боловсруулан мөрдөх, ✓ Тээврийн хэрэгслийн янданд шүүлтүүр тавих, төслийн үйл ажиллагаанд ашиглах машины техникийн оношилгоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцөлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай ✓ Хатуу хог хаягдлыг тогтмол ачуулж, төслийн талбайд удаан хадгалахгүй байх ✓ Зориулалтын замаас гадуур өөр зам гаргахгүй байх тал дээр анхаарах ✓ Хэт халалт, агаарын бохирдол тоосжилтыг бага байлгахын тулд ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх
Дуу чимээ, чичиргээнээс үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> ✓ Авто машины дуут дохиог гэнэтийн ослоос сэргийлэхээс бусад үед өгөхгүй байх, оройны 10 цагаас хойш ямар нэгэн олныг хамарсан дуу чимээ гаргуулахгүй байх ба ажлын бус цагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг багасгах ✓ Шуугианы түвшнийг зохицуулж хянаж байх, чимээ ихтэй тоног төхөөрөмж ашиглахгүй байх, ✓ Ашиглахгүй үед тоног төхөөрөмжөө заавал унтрааж байх.
Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> ✓ Ундны усны хадгалалт цэвэр, эрсдэлгүй байгааг шалгаж баталгаажуулах. ✓ Хатуу/аюултай хог хаягдлын байгаль орчинд ээлтэй болон бусад менежмент хэрэгжүүлэх
Газрын гадаргад үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> ✓ Барилга угсралтын үйл ажиллагаа дууссан даруйд ойр орчмыг хуучин төрхөд ойртуулан нөхөн сэргээх шаардлагатай
Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> ✓ Хатуу хучилтгүй замаар зорчих үед автомашины хурдыг хязгаарлах, ✓ Салбар хооронд болон шугам сүлжээний засвар үйлчилгээний замын сүлжээг сайжруулах, ✓ Онц шаардлагагүй тохиолдолд эрүүл газар хөндөхгүй байх, ✓ Замын нэгдсэн сүлжээг бий болгох, цаашид онц шаардлагагүйгээр шинээр зам бий болгохгүй байх, ✓ Хөрс бохирдуулагч материалуудын хяналт, зохицуулалтыг сайжруулах, ✓ Тээврийн хэрэгслээс шатах, тослох материал асгарахаас сэргийлэх. Асгарсан тохиолдолд түргэн шуурхай сэргийлэх арга хэмжээ авах. ✓ Машин механизмыг зориулалтын талбайд байрлуулах, засвар үйлчилгээг мөн зориулалтын талбайд хийх, ✓ Түлш, тосолгооны материал, химийн бодис агуулах сав гэх мэт болзошгүй эх үүсвэрүүдээс асгаралт үүсэхээс сэргийлсэн хамгаалалтын суурь хийх

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

<p>Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Тоосжилт нь ургамлын навчны амсрыг бөглөх, улмаар фотосинтезийн явцыг бууруулах, ургамлын ургалтыг доройтуулах сөрөг нөлөөтэй юм. Иймд хатуу хучилтгүй замд автомашины хурдыг хязгаарлах, замын сүлжээг сайжруулах, тоосжилтыг бууруулах усалгааг хийх, ✓ Онц шаардлагагүйгээр газар хөндөхгүй байх, ✓ Замын нэгдсэн сүлжээг нэн даруй бий болгох, цаашид онц шаардлагагүйгээр шинээр зам бий болгохгүй байх, ✓ Хөрс бохирдуулагч материалуудын хяналт зохицуулалтыг сайжруулах, ✓ Засвар үйлчилгээ, барилга угсралт болон цахилгаан дамжуулах шугамын ашиглалтын үед хэрэглэгдэх машин, механизмыг тогтмол үзлэг оношилгоонд хамруулах, ШТМ-ын асгаралт үүсгэж байгаа эсэхэд хяналт тавих, ✓ Машин механизмыг зориулалтын талбайд байрлуулах, засвар үйлчилгээг мөн зориулалтын байранд хийх ✓ Түлш, тосолгооны материал, химийн бодис агуулах сав зэрэг асгаралт үүсгэж болзошгүй эх үүсвэрүүдээс асгаралт үүсгэхээс сэргийлсэн хамгаалалтын суурь хийх
<p>Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах арга хэмжээ</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, өндөр давтамж (85 дБА-аас дээш)- тай дуу шуугиан үүсгэх ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх, ✓ Шөнийн цагаар 22:00 — 07:00 цагийн хооронд 45 дБА-аас өндөр давтамжтай дуу шуугиан үүсгэх ажлыг аль болох гүйцэтгэхгүй байх, ✓ Тээврийн хэрэгслүүд зорчих авто замын маршрутыг барилгын ажил эхлэхээс өмнө гаргах, ✓ Ухсан нүхийг тойруулан гэрэл ойлгогчтой тууз татах, тэмдэгжүүлэх, ✓ Тулгууруудыг суурилуулсны дараагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг чанартай гүйцэтгэх, ✓ Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хог хаягдлын нэгдсэн цэгт хаях, ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах, ✓ Барилгын ажлын явцад ойролцоо нутаглаж буй малчидтай нөхөрсгөөр харилцах, иргэдээс төслийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг хүлээн авч зохих арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах зэрэг болно.

БҮЛЭГ 4. ТЖБОМТ-НИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн байдлын үнэлгээний тухайн хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр

дүнд үндэслэн боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан.

Бид бүхэн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013.11.16-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014.04.10-ны өдрийн А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”, БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, тушаалуудыг үндэслэн боловсруулав.

4.2. ТЖБОМТ-НИЙ ЗОРИЛГО, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮР ДҮН

Ажлын зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбай, түүний орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- а) Ажиллагсад бүх байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, ур чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.
- б) Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцож, байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж хамгаална.
- с) Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллана.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн төслийн БОМТ-тэй танилцан баталж, төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох ба жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж, дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. Мөн

БОМТ-ний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, БОАЖГ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй ба тэдгээрт холбогдох мэдээлэл ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг болно.

Бүрэлдэхүүн хэсэг: БОМТ-г доорх үндсэн 2 бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилан авч үзэв. Үүнд:

- а) Байгаль орчны менежмент төлөвлөгөө: Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах үйл ажиллагааг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр: Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

4.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Энэхүү БОХТ-ний ихэнх хэсэг Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй нягт уялдах бөгөөд төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид газрын доорх ус, хөрсний чанар, ургамалжилт, амьтны аймагт гарч байгаа өөрчлөлтүүдийг тухай бүрд нь шинжилж, холбогдох арга хэмжээг жил бүрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байх шаардлагатай.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийн хүрээнд хийгдэх бүхий л үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН
УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

бүхэлд нь тусгасан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэг чухал баримт
бичиг юм

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Биелэлт	Нийт зардал /мян.төг/
АГААР ОРЧИН					
1	Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл	Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Уурхайн бүхий л үйл ажиллагаанд	Төслийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор цаг агаарын 7 хоногийн өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг УЦУОШГ-ын web хуудаснаас өмнөх 7 хоногт тогтмол авч, болзошгүй цаг агаарын аюултай нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж ажилладаг.	500.0
2	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Агаарын тоосжилт үүсгэгч эх үүсвэрүүдийг бүртгэх, мониторинг хийх	Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх агаар бохирдуулагчид	Агаарын тоосжилт үүсгэгч эх үүсвэрүүдийг ОХШХ-т тусгагдсан хуваарийн дагуу бүртгэх, мониторинг хийх ажлыг хийсэн.	
3		Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд агаарын тоосжилтын хэмжилтийг	-Хөрсний овоолго -Ухаш -Тээврийн зам -Бутлах цех	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд агаарын тоосжилтын хэмжилтийг /PM 10, PM 2.5/ шинжлүүлсэн.	ОХШХ-т тусгав.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		шинжлүүлэх /TSP, PM 10, PM 2.5/			
4		Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх /SO ₂ , NO ₂ /	-Хөрсний овоолго -Ухаш -Тээврийн зам -Бутлах цех	Агаарын бохирдлын / SO ₂ , NO ₂ / шинжилгээ хийлгэсэн.	
6		Салхи, шуурга ихтэй үед өрөмдлөг, тэсэлгээ, хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	Уурхайн ашиглалтын талбайд	Салхи, шуурга ихтэй үед өрөмдлөг, тэсэлгээ, хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг уурхайн уулын мастер талбайн инженер, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа хариуцсан инженеүүдийн зааварчилгаагаар хязгаарлан ажиллдаг.	
7		Дотоод болон гадаад тээвэрлэлтийн замыг тогтмол	Гадаад дотоод тээврийн зам	Уурхайн орчинд тоос шороо дэгдэх, агаар орчин бохирдуулах, үзэгдэх орчин хязгаарлагдах зэргээс сэргийлэн дотоод тээвэрлэлтийн замыг услах, замыг хусах ажил долоо хоног бүр тогтмол хийгддэг. Уурхайгаас олборлосон төмрийн хүдрийг борлуулах,	600.0

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		услах, замыг хусаж байх		зөөвөрлөх ажиллагаа одоогоор хийгдэж эхлээгүй тул гадаад тээвэрлэлийн замыг ашиглаагүй бөгөөд замыг ашиглаж эхэлсэн даруйд БОМТ-д заагдсаны дагуу услах, хусах, нягтаршуулах ажлыг тогтмол гүйцэтгээд явна.	
8		Зам талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засч дагтаршуулах	Гадаад, дотоод тээврийн зам	Зам талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засч дагтаршуулах ажил тогтмол хийгдэж байна.	Үйл ажиллагааны зардалд
9		Хүдэр тээвэрлэхдээ тоосжилт бууруулах зорилгоор машины ачаанд хучилт хийж тээвэрлэх	Хүдэр тээвэрлэж буй авто тээврийн машинд	Уурхайгаас олборлосон төмрийн хүдрийг борлуулах, зөөвөрлөх ажиллагаа одоогоор хийгдэж эхлээгүй байгаа бөгөөд энэ үйл ажиллагаа эхэлмэгц машины ачаанд хучилт хийж тээвэрлэж байхаар бэлтгэл ажлыг хангасан.	1 000.0
10	Дуу чимээ, шуугиан	Барилга байгууламжийн барилгын ажлын үед 22:00 цагаас хойш ажиллахгүй	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Уурхайн талбай дээрх барилга байгууламжууд нь одоогийн байдлаар түр кемп болон ажилчдын амрах гэр, хоолны газар зэрэг байгаа бөгөөд байрилга угсралтын ажлыг 22:00 цагаас хэтрүүлэхгүйгээр барьж, угсарч ашиглалтад оруулсан. Боловсруулах үйлдвэрийн барилга баригдаж эхлээгүй.	Үйл ажиллагааны зардалд

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		байх			
11		Тэсэлгээ хийхээс өмнө малчдад мэдэгдэх Дүн	Тэсэлгээ хийх бүрт	Тэсэлгээ хийхийн өмнөх өдөр болон тухайн өдөр 2-3 цагийн өмнө малчдад биечлэн очиж мэдэгдэж хэвшсэн.	--*--
					6,100.00
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ					
12	Газрын гадарга эвдэрч, Хөрсний үржил шим алдагдах, бохирдох, эвдрэх, доройтох	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж хадгалах	Үйл ажиллагаа эхлэх үед, шинэ газар хөндөх бүрт	Уурхайн олборлолтод өртөх хэсгийн шимт хөрс, зам талбай болон хаягдлын овоолго байршуулах хэсгийн шимт хөрсийг стандартын дагуу хуулж нөхөн сэргээлт хийх үед буцаан ашиглахаар хадгалсан.	ҮАЗ
13		Авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчих, олон салаа зам гаргахгүй байх, замыг тэмдэгжүүлэх	Уурхай хэмжээнд	Уурхайн талбайд авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчуулж хэвшсэн. Олон салаа зам гаргахгүй байх зааварчилгааг жолооч нарт өгч, замыг тэмдэгжүүлсэн.	1 000.0

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

14		Эвдэрсэн зам талбайг засварлах	Төсөл хэрэгжих талбайд	Эвдэрсэн зам талбайг уурхайн үйл ажиллагааны хүрээнд тогтмол засварлаж ажилладаг.	ҮАЗ
16		Хог хаягдлаар дамжин хөрсний бохирдол үүсгэхгүйн тул хог хаягдлын эцсийн цэгт хүргэх	Ахуйн хог хаягдлын цэг	Даланжаргалан сумын Засаг даргатай хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээнд заагдсаны дагуу хог хаягдлыг ангилан ялгаж эцсийн цэгт хүргэн хаях ажлыг тогтмол зохион байгуулдаг. Гэрээний дагуу Даланжаргалан суманд хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлж сар бүр төлбөрийг төвлөрүүлэн ажиллаж байна.	200.0
17		Нүхэн жорлонгийн бохирдол хөрс рүү нэвчихээс сэргийлж дотор ханыг бетон болгох	Нүхэн жорлон	Нүхэн жорлонгийн бохирдол хөрс рүү нэвчихээс сэргийлж жорлонгуудыг барих үед зориулалтын бетонон гольцоо суурьлуулсан.	500.0
18		Хог хаягдлыг тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгах,	Хогийн цэг	Даланжаргалан сумын Засаг даргатай хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээнд заагдсаны дагуу хог хаягдлыг ангилан ялгаж эцсийн цэгт хүргэн хаях ажлыг тогтмол зохион байгуулдаг. Хог хаягдлаас үүдэлтэй хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан	500.0

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		ариутгах зайлуулах		сэргийлэх, бууруулах, арилгах зорилгоор “Хог хаягдлын тухай хууль”, “Байгаль хамгаалах тухай хууль” болон байгууллагын дотоод “Хог хаягдлын журам”-ыг нийт ажилчдад танилцуулж, сургалт зохион байгуулж, зааварчилгаа өгсөн байна.	
19	Ургамлан нөмрөг талхлагдах ас сэргийлэх	Уурхайн тосгоны тоосжилтын бууруулж, мод, бут тарих, зүлэгжүүлэх	Барилга байгууламжаас бусад талбай	Уурхайн олборлолтын үйл ажиллагаа эхлээд удаагүй байгаа тул уурхайн тосгонд мод, бут тарих зүлэгжүүлэх улирлын шинж чанартай ажил хараахан хийгдээгүй. Харин тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж байгаа.	Тэрбум мод хөтөлбөрийн арга хэмжээнд тусгасан
20		Шимт хөрсний овоолгыг салхинд хийсч үржил шимийг алдахаас сэргийлэн ургамалжуулах		Шимт хөрсний овоолгыг салхинд хийсч үржил шимийг алдахаас сэргийлэн ургамалжуулах ажил нь улирлын шинж чанартай тул ирэх хавар хийгдэнэ.	800.0
Дүн				3,000.0	
ГАДАРГЫН ДООРХ УС					
21	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвилан хэмнэх, ус	Уурхайн ажилчид	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвилан хэмнэх, ус хэмнэлтийн менежментийг хэрэгжүүлэх зорилгоор кемпийн ажилчдад сургалт зохион байгуулсан.	150.0

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

	зориулалтаар усыг хэмжээгээр ашигласнаар усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	хэмнэлтийн менежмент хэрэгжүүлэх			
22		Жил бүр ус ашиглуулах дүгнэлтийг “Усны газар”-аар гаргуулж ажиллах	Уурхайн талбайн хэмжээнд	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар 2025 оны 06 сарын 04-ны Е-2505-000242 тоот “Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт” болон Умард говийн гүвээт-Халхын дундад талын Сав газрын захиргаагаар 2025 оны 09 сарын 10-ны Е-2508-000248 тоот “Ус ашиглуулах дүгэлт”-үүдийг тус тус гаргуулсан.	250.0
23	Газрын доорх ус	Ашиглалтын худгийг тоолууржуулах	Уурхайн гүний худагт	Ашиглалтын худгийг тоолууржуулсан.	600.0
24		Гүний худгийн усны түвшинг тогтмол хэмжиж байх	Уурхайн гүний худагт	ОХШХ-т тусгагдсаны дагуу Гүний худгийн уснаас шинжилгээ авах бүрт усны түвшинг тогтмол хэмжиж ажиллаж байна.	ОХШХ-т тусгав.
27		Гүний усны чанарын үзүүлэлтийг шинжлүүлж, хяналт тавих	Ашиглалтын худагт	ОХШХ-т тусгагдсаны дагуу ашиглалтын худгаас гүний усны чанарын үзүүлэлтийг шинжлүүлэх хяналт, шинжилгээг стандартын дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.	
28					
НИИТ				6,200.0 төгрөг	

Зураг 3: Тоосжилт үүсэхээс сэргийлэн уурхайн зам талбайг услаж, дагтаршуулж буй үеийн зураг



БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уул-техникийн нөхөн сэргээлт: Хөрсний овоолгыг тэгшлэх, хэлбэршүүлэх, уурхайн зам орчмыг налуулах зэрэг ажлуудыг тогтмол хийж байна. Техникийн нөхөн сэргээлтийн ажлаар овоолгыг 26° хүртэл налуулж хэвгийжүүлэх ба уурхайн хана хэсэгт хаалт барих, аюулгүйн тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ажлуудыг хийсэн. Уурхайд олборлолтын үйл ажиллагаа эхлээд удаагүй байгаа тул техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөлтийн дагуу шимт хөрс хуулах, шимт хөрс ачих, зөөх овоолох, овоолго хэлбэржүүлэх ажлууд хийгдэж байна. Талбай тэгшлэлтийн ажил, Шимт хөрс ачих, зөөх, асгах ажил, Шимт хөрсөөр хучих ажил, Биологийн нөхөн сэргээлт хийх зэрэг ажлууд ашиглалтын 3, 4 дэх жилд хийгдэхээр төлөвлөсөн.


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 8. Жилд хийгдэх ажлын хэмжээ

№	Үзүүлэлт	Нэгж	1 жил	2 жил	3 жил	4 жил	Нийт
1	Шимт хөрс хуулах ажил	мян.м ³	33.61	57.65			91.26
2	Шимт хөрс ачих, зөөх овоолох ажил	мян.м ³	33.61	57.65			91.26
3	Овоолго хэлбэршүүлэх ажил	мян.м ³	133.7	97.9			231.53
4	Талбай тэгшлэлтийн ажил	га				7.20	7.20
5	Шимт хөрс ачих, зөөх, асгах ажил	мян.м ³				91.26	91.26
6	Шимт хөрсөөр хучих ажил	мян.м ³				73.0	73.0
7	Биологийн нөхөн сэргээлт	га			3.0	14.9	17.90

Батлагдсан ТЭЗҮ-д тусгагдсанаар эхний 1-2 жилд шимт хөрс хуулах , стандартын дагуу хадгалах ажлууд хийгдэх бөгөөд 3 -4 дэх жилүүдэд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг ил уурхайг ашиглаж дууссаны дараа хийгдэхээр төлөвлөсөн байна. Иймээс тухайн жилд биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй байна. Харин уурхайн олборлолтод өртөх хэсгийн шимт хөрс, зам талбай болон хаягдлын овоолго байршуулах хэсгийн шимт хөрсийг стандартын дагуу хуулж нөхөн сэргээлт хийх үед буцаан ашиглахаар хадгалсан.

Зураг 4: Шимт хөрсний овоолгони



БҮЛЭГ 7. “ТЭРБУМ МОД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Төлөвлөгөөний хүрээнд МУ-ын ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 мод тарих ажлыг хийж гүйцэтгэхээр тусгасан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэхдээ Даланжаргалан сумын засаг дарга, байгаль орчны байцаагч, мэргэжилнүүдтэй хамтран төлөвлөсөн газарт 1000 мод тарихаар суулгацын дэмжлэг үзүүлсэн бөгөөд сумын байгаль орчны байцаагчийн сонгосон газарт мод тарих ажлыг хамтран гүйцэтгэсэн.

Зураг 5: Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 мод тарих ажлын гүйцэтгэл


ДОРНОГОВЬ АЙМАГ
ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
200, Их сансар гудамж, Цомог баг,
Даланжаргалан сум, Дорноговь аймаг, 44133
Утас: (02-524) 1-41-70
Цахим шуудан: zdtg@dalanjargalan.do.gov.mn

2025.10.27 № 01/597
танай _____ -ын № _____ -т

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ

Тус сумын Элдэв багт MV-022826 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч “Ундармал Хүдэр” ХХК-н “ТЭР БУМ МОД” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус суманд 1000 (мянга) модны суулгацын дэмжлэг үзүүлсэн нь үнэн болно.


С. БАЯРСАЙХАН

4425070060



БҮЛЭГ 8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 9. Биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний зардал

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Гүйцэтгэл	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
2	Биотехникийн арга хэмжээ авах	Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүнд зэрлэг амьтад жил бүрийн өвөл, хаврын улиралд орон нутаг болон мэргэжлийн байгууллагатай хамтран өвс тэжээл, хужир мараа, мөс тавьж өгөх	Ган, зудтай жилүүдэд зэрлэг ан амьтанг хамгаалах арга хэмжээг орон нутаг, мэргэжлийн байгууллагатай хамтарч хэрэгжүүлэх	Зэрлэг амьтдад жил бүрийн өвөл, хаврын улиралд орон нутаг болон мэргэжлийн байгууллагатай хамтран өвс тэжээл, хужир мараа, мөс тавьж өгдөг ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэж байна.	Жил бүр	Амьтны тухай хууль
2025 оны дүйцүүлэн хамгаалсан арга хэмжээний нийт зардал (төг)					2736.300 төгрөг	

Зураг 5: Зэрлэг ан амьтанг хамгаалах, өвс тэжээл тавьж өгч буй үеийн зураг



НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Далан-Ухаа төмрийн хүдрийн ордыг ил, далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас нутгийн ард иргэд, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх шаардлагад 1 айл байрлаж байгаа бөгөөд тэрхүү айлын хашаа бууцыг нүүлгэн шилжүүлэхээр тухайн айлтай зөвшилцөж 12 120 000 төгрөгийг шилжүүлсэн.

БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн талбайд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Палеонтологийн хүрээлэн болон, Монгол Улсын Их Сургуулийн Археологийн судалгааны төвүүдээр археологи, палеонтологийн хайгуул, судалгааны ажил хийлгэхэд ямар нэгэн дурсгалт зүйлс болон соёлын олдвор илрээгүй. Гэвч үйл ажиллагааны явцад олдвор олдсон тохиолдолд ажлаа зогсоож “Соёлын өвийг хамгаалах хууль”-ийн дагуу сум, дүүргийн удирдлага, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэж мэргэжлийн мониторинг хийлгэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахаар БОМТ -д тусгасан. Одоогоор төслийн талбайгаас түүх, соёлын өв, дурсгалт зүйл олдоогүй болно.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 10. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Цар хүрээ	Гүйцэтгэл	Баримтлах стандарт ба аргачлал
Төсөл хэрэгжиж буй талбайд археологи, палеонтологийн олдвор гарсан тохиолдолд	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран нүүлгэн шилжүүлэх, музей эсвэл эрх бүхий төрийн байгууллагад шилжүүлэх	Олдвор олдсон тохиолдолд	Одоогоор төслийн талбайгаас түүх, соёлын өв, дурсгалт зүйл олногүй.	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу

Зураг 6: Талбай дээр хийгдсэн археологи, палеонтологийн хайгуул, судалгааны ажлын үр дүн

The image shows several documents:

- Top Left:** Title page of a survey report from the Mongolian Academy of Sciences, Institute of Archaeology and Paleontology, dated 2023-06-19.
- Top Center:** Logo and header of 'UNDARMAAL KHUDAR' LLC, a company registered in the State Register of Mongolia.
- Top Right:** A document titled 'UNDARMAAL KHUDAR' LLC-ийн ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ 6205.15 ГА "ДАЛАН УХАА" НЭРТЭЙ XV-022087 ТООТ ХАЙГУУЛЫН ТУСАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАН ПАЛЕОНТОЛОГИЙН НООЦ БАЯЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН'.
- Middle Left:** Text describing the survey work conducted in 2022 on the 10-ravine area of the Dorноговь aimag, mentioning the discovery of archaeological remains.
- Middle Right:** A list of survey results with columns for 'Гэрээний дугаар' (Contract No.), 'Захиалгыг' (Order), 'Гүйцэтгэгч' (Executor), and 'Д.Доржнамжаа' (D. Dorjnamjaa). It includes signatures of experts.
- Bottom Left:** A signature block for 'ЗАХИРАЛ, ДОКТОР, ПРОФЕССОР Ц.ЦОГТБААТАР' (Director, Doctor, Professor T. Tsogtbaatar).

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 11. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Гүйцэтгэл	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Хээрийн түймэр уурхайн талбай, кемп рүү орж ирэх, уурхайн хээрийн түймэрт өртөх	Хээрийн түймрээс сэргийлж уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулах	Хээрийн түймрээс сэргийлж уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулсан.	Жил бүр
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллаж байна.	2025 онд
	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулж, ажилчдад заавар зөвлөмж өгсөн.	Жил бүр
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйцаар байрлуулсан.	Жил бүр уурхай эхлэх үед
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө уурхайн ХАБЭА-н инженер аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тогтмол хамруулдаг	Өдөр бүр ээлжинд гарахын өмнө
	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан. Уурхайн хэмжээнд Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журамыг боловсруулан батлаж мөрдлөг болгон ажилладаг.	Жил бүр, жилд 1 удаа
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай	Яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулсан.	Жил бүрийн I улиралд байрлуулан сар бүр шалгаж байх

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

	анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулах		
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Уурхайд ажиллаж байгаа ажилчдын хувцас хамгаалах хэрэгслийг бэлтгэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Гүйцэтгэх захирлын тушаалаар “Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл олгох, ашиглах журам”-ийг гаргаж тус тушаалын дагуу нийт ажилчдыг ажлын тусгай хувцсаар ханган ажилласан. Уурхайн ХАБЭА-н инженер ажилчин нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны ашиглалт ба олголтын журмыг дагаж мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.	Жил бүр
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	<ul style="list-style-type: none"> - Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах 	Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан; Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад бүрэн байрлуулсан; Уурхайн талбай дотор таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан	Жил бүр, жилд 1 удаа
Нийт зардал		2,800.0 төгрөг	


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Зураг 7: Уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулсан зураг



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Зураг 8: Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан зураг



Уурхайд ажиллаж байгаа ажилчдын хувцас хамгаалах хэрэгслийг бэлтгэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Гүйцэтгэх захирлын тушаалаар “Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл олгох, ашиглах журам”-ийг гаргаж тус тушаалын дагуу нийт ажилчдыг ажлын тусгай хувцсаар ханган ажилласан. Уурхайн ХАБЭА-н инженер ажилчин нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны ашиглалт ба олголтын журмыг дагаж мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.

Уурхайн үйл ажиллагааны хүрээнд тэсэлгээний зориулалтаар тэсрэх материал ашигладаг бөгөөд тайлант онд 2 удаагийн тэсэлгээгээр нийт 24625 кг **АНФО (ANFO, Ammonium Nitrate/Fuel Oil)** бодисыг ашигласан. Уул уурхайн салбарт АНФО нь аммонийн нитратын прилл ба дизель түлшний холимогоор тусгайлан тодорхойлдог. АНФО нь хими дээр суурилсан байдаг бөгөөд түүнээс гадна бусад тэсрэх бодисууд байдаг ба бусдаас хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь эмульс юм. Аммонийн нитратыг дангаар нь зөвхөн түүхий эд гэж ангилдаг ба тэсрэх бодис гэж ангилах шаардлагагүй байдаг ба энэ нь зүгээр л исэлдүүлэгч бодис юм. Бид аммонийн нитратыг ашиглахдаа өдөөгч болон тэсэлгээний хэрэгсэлтэй хамт ачиж, тээвэрлэхийг хориглосон ба АНФО-г зориулалтын шуудайнд үйлдвэрлэж, тээвэрлэж, уурхайд гар аргаар цооног цэнэглэж, тэсэлгээний ажил хийж болдог дүрмийн дагуу осол эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна.

Мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан. Уурхайн хэмжээнд Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журамыг боловсруулан батлаж мөрдлөг болгон ажилладаг.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Зураг 9: Ажилчдыг аюулгүй ажиллагааны сургалтад хамруулж, заавар зөвөлгөө өгч байх үеийн зураг



Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулж, ажилчдад заавар зөвлөмж өгсөн. Мөн яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байрлуулсан.

Зураг 10: Галын сарай болон анхан шатны тусламжийн эмийн сангийн зураг




ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Уурхайн хэмжээнд Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн дотоод журам, Галын аюулгүй байдлыг хангах журам, Ажлын байрны аюулгүйн ажиллагааны журам, Уурхайн яаралтай тусламжийн нэгжийн журам, Уурхайн бүсэд замын хөдөлгөөнийг зохицуулах, өөрчлөх журам, Ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулах журам зэргийг боловсруулан батлаж мөрдлөг болгон ажилладаг. Журмын хэрэгжилтэд уурхайн ХАБЭА-н инженер, уурхайн дарга, кемпийн менежерүүд хяналт тавин өдөр тутмын аргагүйгээр ханган ажиллаж хэвшсэн.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Зураг 10: Уурхайн хэмжээнд батлаж мөрдүүлж буй дотоод журамаас



БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АРГА ХЭМЖЭЭ

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

2025 оны Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу Далан-Ухаа уурхай нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газартай хамтран хог хаягдлын гэрээг байгуулан ажиллаж байна.

Эзэмшил газрынхаа ойр орчны цэвэрлэгээг тогтмол хийх, үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг тогтоосон цэгт хуримтлуулж тогтмол хугацаанд зайлуулах, ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг ашиглах, аливаа зүйлээр бохирдсон хог хаягдлыг саармагжуулах, галын аюулаас хамгаалах, хадгалалт хамгаалалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалахдаа хогийн сав болон хогийн цэгийг өнгөөр ялгаж зургаар тэмдэгжүүлснээр хуурай хог хаягдлыг стандартын дагуу ачиж, тээвэрлэх хадгалах нөхцөл бүрдүүлэн, мөн гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй бохирдолгүй амьдрах нөхцөл бололцоог бий болгон ажиллаж байна.

Хатуу хог хаягдлаа ялган ангилсны ач холбогдол:

- Цаас, шил, мод, яс, хуванцар, металл, органик гаралтай хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах боломж бий болно.
- Орчныг бохирдуулах, устгал хийх хогны хэмжээ эрс багасна.
- Хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр ачиж тээвэрлэх боломж бүрдэнэ.
- Хүн амын аюулгүй, цэвэр, эрүүл орчинд ажиллах, амрах нөхцөл бүрдэнэ.
- Амьтан, ургамал, хөрс, усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН


Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Гүйцэтгэл	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Үйл ажиллагааны турш	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулсан бөгөөд эцсийн цэгт тушаах ажлыг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгэж байна	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС зэрэг газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС зэрэг газарт байрлуулсан	
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Үйл ажиллагааны турш	Хаягдал ажилласан тосыг дахин боловсруулах үйлдвэрт өгөхөөр төлөвлөн тусгай саванд цуглуулж байна.	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулсан	
Хог хаягдал тархах	Хог хаягдлын тухай сургалтыг ажилчдад олгох	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	Хог хаягдлаас үүдэлтэй хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зорилгоор “Хог хаягдлын тухай хууль”, “Байгаль хамгаалах тухай хууль” болон байгууллагын дотоод “Хог хаягдлын журам”-ыг нийт ажилчдад танилцуулж, сургалт зохион байгуулж, зааварчилгаа өгсөн байна.	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
НИЙТ ДҮН			2500.0 төгрөг	


ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулсан бөгөөд эцсийн цэгт тушаах ажлыг тогтмол хуваарийн дагуу гүйцэтгэж байна. Хаягдал ажилласан тосыг дахин боловсруулах үйлдвэрт өгөхөөр төлөвлөн тусгай саванд цуглуулдаг. Хог хаягдлаас үүдэлтэй хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зорилгоор “Хог хаягдлын тухай хууль”, “Байгаль хамгаалах тухай хууль” болон байгууллагын дотоод “Хог хаягдлын журам”-ыг боловсруулан ажилчдад танилцуулж, сургалт зохион байгуулж, зааварчилгаа өгсөн.

Зураг 11: Хогийн сав болон ажилласан тос масло хадгалах савны зураг



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 5. Хог хаягдлын цэгийн шийдэл

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Төслийн талбайд Хог хаягдлын цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дараах заалтын дагуу барьж байгуулан ашиглаж байна.

Төслийн талбайд хийгдсэн Хог хаягдлын цэгийг Зураг 2-д харуулснаар хийсэн ба хог хаягдлыг энгийн, дахивар, аюултай хог хаягдал гэж 3 ангилан ялгаж байна.

Хүснэгт 13. Ангиан ялгаж буй хог хаягдлууд

Энгийн хог хаягдал	Дахивар хог хаягдал	Аюултай хог хаягдал
<ul style="list-style-type: none"> ✓ Хоолны үлдэгдэл; ✓ Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл; ✓ Яс; ✓ Хэрэглэсэн хүнсний тос ✓ Аюултай болон дахин боловсруулах хог хаягдлаас бусад хог хаягдал 	<ul style="list-style-type: none"> ✓ Цаас /хэт бохирдоогүй сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетрапак савлагаа/ ✓ Хуванцар /төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, 0,025 мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав, гм/ ✓ Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл; ✓ Шил /хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл/; ✓ Лааз; ✓ Мод, модон эдлэлийн хаягдал; ✓ Хувцас, даавуун эдлэл; ✓ Савхи, резин; ✓ Өвс, мод. 	<p>Аюултай хог хаягдал гэж амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх хог хаягдлыг хэлнэ.</p> <p>Иймд Төслийн үйл ажиллагаанаас гарч буй нефть болон газрын тосны бүтээгдэхүүн агуулж буй сав, савны цэвэрлэгэнд ашигласан цэвэрлэгээний материал, тос тосон бүтээгдэхүүн агуулж буй савны хаягдлыг энэ цэгт төвлөрүүлж Хог хаягдал тээвэрлэх машинд ачуулж тусгай цэгт хүргүүлнэ.</p> <p>Аюултай хог хаягдлыг ялгаж, хөрсөнд үл нэвчих гадаргуутай, хальж урсахаас хамгаалсан хашилт хаалт, борооны ус, нарын тусгал, механик хольц орохоос хамгаалсан саравчтай, тэмдэг, тэмдэглэгээ, галын хортой зориулалтын цэгт түр хадгалж байна.</p>

Хог хаягдлыг цуглуулахад дараах ерөнхий шаардлагыг баримталж байна

2.3.1. Энгийн хог хаягдлыг цуглуулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг ойлгох ба хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас гадна энэхүү тавигдах ерөнхий шаардлагын 2.3.2-2.3.5-д заасан ерөнхий шаардлага хамаарна.

2.3.2. Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т заасан гэрээнд хог хаягдал цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар тодорхой тусгасан байна.

2.3.3. Хог хаягдлыг цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмж гэж энгийн хог

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах зорилгоор хог хаягдлыг цуглуулж байгаа хог хаягдал үүсгэгчийн ойролцоо байршуулсан савыг хэлэх ба дараах ерөнхий шаардлага хангасан байна.

а. Хог хаягдал цуглуулах сав, төхөөрөмжийг сум, хорооны Засаг даргын зөвшөөрсөн хэлбэр, хэмжээ, зориулалт болон заасан газарт байгуулна.

б. Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байна.

в. Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.

г. Хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ил харагдахуйц байршуулсан байна.

д. Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцөлөөр буюу чанарын шаардлага хангасан байна.

е. Тээвэрлэх зориулалт бүхий уяа, дэгээтэй, хог хаягдал ачих тээврийн хэрэгсэлд зориулагдсан байна.

ж. Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмжийн хог хаягдал хадгалах, цуглуулах багтаамж 3 хоногоос ихгүй байна.

2.3.4. Хог хаягдал цуглуулах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ажилтан нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

а. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх; б. Хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгсэл хэрэглэх;

в. Хог хаягдал цуглуулах үйл ажиллагааны бүрэн мэдлэгтэй, хог хаягдал үүсгэгчийн онцлогийг тодорхойлох чадвартай байх.

2.3.5. Хог хаягдлын цуглуулахдаа ангилан ялгасан хог хаягдал тус бүрээр цуглуулна.

БҮЛЭГ 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

БОННУ-ний тайлан, БОХТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд “Ундармал хүдэр” ХХК-ийн “Далан-ухаа төмрийн хүдрийн ордыг ил, далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, хяналт хийж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгасан.

БОХШХ нь байгаль орчин, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг юм. Цаашдаа БОХТ-г улам боловсронгуй болгох байгаль орчин, нийгэм-эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчлан тогтоох боломжтой болно.

Манай компани нь БОМТ-г жил бүр шинэчлэн боловсруулж тухайн оныхоо эхэнд БОУАӨЯ-аар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг мөн БОУАӨЯ-д тайлагнана. Хяналт-шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлнэ.

Хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар, хороо дүүргийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээний байршил	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар				
1.1	Агаарын тоосны шинжилгээг хийлгэх /Нийт тоосонцор, PM10, PM2.5/	Үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт	Тоосжилт үүсгэх эх үүсвэрүүдэд Уурхайн ухаш 108° 48' 42.070" 46° 6' 25.710" Хөрсний овоолгын салхины дор 108° 48' 57.122" 46° 6' 13.787"	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажилл лагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх /SO ₂ , NO ₂ /	Үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт	Гадаад тээвэрлэлтийн зам 109° 16' 7.662" 46° 6' 33.159"	
Хөрсний бохирдол				

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2.1	Хөрсний агрохими хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Шимт хөрсний овоолго 108° 48' 57.436" 46° 6' 25.470"	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг
2.2	Хөрсний хүнд металлын агууламж	Хөрс хүнд металлаар бохирдох, хөрс рүү нэвчих, гүний усыг бохирдуулах /Zn, Cu, Cr, As, Pb, Ni, Cd, NH4/	ШТС 109° 15' 42.803" 46° 6' 47.904" Үйлдвэрийн цех 108° 48' 28.283" 46° 6' 3.763" Кэмп 108° 48' 3.212" 46° 6' 26.320"	
2.3	Хөрсний эрүүл ахуй, микробиологи	Хөрсөөр дамжин гэдэсний халдварт өвчин, нянгийн өвчнөөр өвчлөх	Кэмп 108° 48' 3.212" 46° 6' 26.320"	
Усны хяналт шинжилгээ				
2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ	Гүний худгаас болон нөлөөллийн бүсийн 5 км-т байгаа 6 малчны худагт	Өөрсдийн хэрэглэх гүний худаг 109° 16' 59.029"	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2.2	Усны чанар Микробиологи	Усны эрүүл ахуйн шинжилгээ	46° 7' 40.510" Худаг 108° 39' 29.9" 46° 07' 3.1"	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
2.3	Усны түвшин усны ундарга, нөөц	Гүний худгаас болон нөлөөллийн бүсийн 5 км-т байгаа 6 малчны худаг		
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН			2,766.0 төгрөг	

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

12.1. АГААРЫН ЧАНАР

Орчны тоосжилтын хяналт шинжилгээ

Хүрээлэн буй орчны агаарын чанарын нэг гол үзүүлэлт нь тухайн орчны агаарын тоосжилт байдаг. Далан-Ухаа төсөл хэрэгжиж байгаа Даланжаргалан сумын нутаг нь физик газарзүйн мужлалаар заримдаг цөл, цөлөрхөг хээрийн бүсэд хамаарах бөгөөд хөрсний физик шинж чанарын хувьд эмзэг, элэгдэл эвдрэлд амархан ордог онцлогтой. Ийм учраас төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс элэгдэл эвдрэлд орж түйрэн үүсэх, орчинд тоосжилт үүсэж улмаар хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй юм. Тоосжилт гэдэг нь нэгж эзлэхүүнтэй агаар дахь янз бүрийн хэмжээтэй, нүдэнд үзэгдэхээс эхлээд нүдэнд үл үзэгдэх өчүүхэн жижиг хэмжээтэй механик хатуу \ аэрозоль \ зүйлсийг хэлдэг. Эдгээр хатуу хэсэг нь өөрсдийн хувийн жин, тухайн үеийн салхины хурд зэргээс шалтгаалан тухайн орчны агаарт байх хугацаа, тархах замын урт зэрэг нь харилцан адилгүй байдаг байна. Агаар дахь тоосны хэмжээг түүний хөндлөн огтлолын уртын хэмжээгээр хэмждэг ба микрометр \ μm \ нэгжээр илэрхийлдэг.

Хэмжилтийн арга, аргачлал, багаж хэрэгсэл

Орчны тоосны хэмжилтийг болон Агаарын чанарын хэмжилтийг **Temtop M2000C Air Quality Monitor /CO2 Monitor Portable Air Quality Monitor for Carbon Dioxide PM2.5 PM10 Formaldehyde/** загварын багажаар хэмжив. Хэмжилтийг тус бүр 1 цагийн урттайгаар Монгол улсын стандарт MNS4585:2016 “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” стандартад заагдсан PM10 болон PM2.5 хэмжээтэй тоосонцор, агаар бохирдуулагч хий болох CO₂, HCHO-ийг хэмжсэн. Төслийн хувьд одоогоор гадаад тээвэрлэлт хийж эхлээгүй байгаа учир уурхайн дотоод тээвэрлэлтийн замын ойролцоо хэмжилт хийж ОХШХ-т тусгагдсан нийт 3 цэгт тоосны хэмжилтийг хийсэн.

Хүснэгт 15. Агаарын чанарын хэмжилт хийх цэгүүдийн байршил

№	Хэмжилтийн цэгийн дугаар	Байршил	Цэгийн координат	
			N	E
1		Үйлдвэрийн цех	46° 6' 25.710"	108° 48' 42.070"
2		Хөрсний овоолгын салхины дор	46° 6' 13.787"	108° 48' 57.122"
3		Гадаад тээвэрлэлтийн зам	46° 6' 33.159"	109° 16' 7.662"

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

1. Уурхайн дотоод тээвэрлэлтийн зам дээр тоосны хэмжилтийг 1 цагийн урттайгаар 7 удаа хэмжилт хийхэд PM2.5 хэмжээтэй тоосонцорын агууламж 4.9 мкг/м³ – 17.9 мкг/м³ хооронд, PM10 хэмжээтэй тоосонцрын агууламж 8.3 мкг/м³ – 29.3 мкг/м³ хооронд хэлбэлзэж байсан ба машин явж өнгөрсний дараа тоосонцрын хэмжээ хамгийн өндөр цэгтээ хүрч байсан. CO2-ийн агууламж 397-408 ppm хооронд хэлбэлзэж байсан.

Хүснэгт 16. Дотоод тээвэрлэлтийн замын агаарын чанарын хэмжилтийн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	1 дэх хэмжилт	2 дахь хэмжилт	3 дахь хэмжилт	4 дэх хэмжилт	5 дахь хэмжилт	6 дэх хэмжилт	7 дэх хэмжилт
1	PM2.5	17.9	17.9	15.2	9.9	4.9	12.5	8.2
2	PM10	29.3	29.2	24.6	16.3	8.3	20.2	13.4
3	CO2	408		402	402	397	402	402
4	НСНО	0.010		0.010	0.010	0.011	0.010	0.011

Зураг 13: Уурхайн дотоод тээвэрлэлтийн замын агаарын тоосжилт болон чанарын хэмжилт



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



1. Үйлдвэрийн цех дээр тоосны хэмжилтийг мөн 1 цагийн урттайгаар 6 удаа хэмжилт хийхэд PM2.5 хэмжээтэй тоосонцорын агууламж 4.3мкг/м3 – 5.5мкг/м3 хооронд, PM10 хэмжээтэй тоосонцрын агууламж 6.1мкг/м3 – 8.9мкг/м3 хооронд хэлбэлзэж байсан. CO2-ийн агууламж 420-440 ppm хооронд хэлбэлзэж байсан.

Хүснэгт 17. Үйлдвэрийн цех орчмын агаарын чанарын хэмжилтийн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	1 дэх хэмжилт	2 дахь хэмжилт	3 дахь хэмжилт	4 дэх хэмжилт	5 дахь хэмжилт	6 дэх хэмжилт
1	PM2.5	4.3	4.5	5.5	5.5	4.9	5.2
2	PM10	6.1	6.1	8.9	8.9	8.6	8.8
3	CO2	424	420	440	433	431	435
4	HCHO	0.022	0.020	0.020	0.019	0.020	0.022

Зураг 14: Уурхайн үйлдвэрийн цех орчмын агаарын тоосжилт болон чанарын хэмжилт



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2. Хөрсний овоолгын салхины доор тоосны хэмжилтийг 1 цагийн урттайгаар 4 удаа хэмжилт хийхэд PM2.5 хэмжээтэй тоосонцорын агууламж 5.5мкг/м³ – 7.8мкг/м³ хооронд, PM10 хэмжээтэй тоосонцорын агууламж 8.9мкг/м³ – 12.7мкг/м³ хооронд хэлбэлзэж байсан. CO₂-ийн агууламж 385-413 ppm хооронд хэлбэлзэж байсан.

Хүснэгт 18. Хөрсний овоолго орчмын агаарын чанарын хэмжилтийн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	1 дэх хэмжилт	2 дахь хэмжилт	3 дахь хэмжилт	4 дэх хэмжилт
1	PM2.5	6.2	7.8	6.2	5.5
2	PM10	10.8	12.7	10.8	8.9
3	CO ₂	385	385	385	413
4	HCNO	0.014	0.014	0.014	0.012

Зураг 15: Уурхайн үйлдвэрийн цех орчмын агаарын тоосжилт болон чанарын хэмжилт



Тоосны хэмжилтийн үр дүн

Тоосны хэмжилтийг төмөр замын төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу 3 цэг дээр хийж гүйцэтгэв. Хэмжилтийн үр дүнгээс харахад Tamtop M2000 багажаар PM10 болон PM2.5 хэмжээтэй тоосонцор, агаар бохирдуулагч хий болох CO₂ -ийн хэмжилтийг хийхэд Монгол улсын стандарт MNS4585:2016 “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” стандартын шаардлага хангаж байна.

12.2. ХӨРСНИЙ БОХИРДОЛ

Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл /2024.09 сар/

Манай компани нь 2024 оны 09 дүгээр сард буюу төсөл эхлээгүй, газрын гадарга нөлөөлөлд өртөөгүй үед “Гурвантайга” мэргэжлийн байгууллагаар “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа”-ны ажил хийлгэх үед гарсан дүгнэлтийг одоогийн ОХШХ-ийн хүрээнд хийж буй хөрсний бохирдлын хяналт, шинжилгээтэй харьцуулах үүднээс энэ хэсэгт нэмэлтээр орууллаа.

Энэ газарт чулуулгийн хэмхдэстэй, хатуураагүй элс, элсэнцэрээр чигжигдсэн делювийн хурдас дээр бий болсон гүвээрхэг болон тэгшивтэр талын цайвар хүрэн хөрс тархсан байна. Багаас дунд зэрэг талхлагдсан.

Хөрсний үржил шимээр ялгаатай байх магадлалтай 5 байрлалд авсан 0-20, 20-40, 0-40, 40-60 үе давхаргуудад задлан шинжилгээ хийлгэхэд “Ундармал хүдэр” ХХК-ийн хөрсний голлох физик, химийн шинж чанар дараах байдалтай байна. Үүнд:

Гүвээрхэг болон тэгшивтэр тал хөндийн цайвар хүрэн хөрсний ялзмагийн агууламж дээж **№ 1 дээжний** 0-20 үе давхаргад ялзмагийн агууламж 2.29%, хөрсний урвалын орчин pH 8.01 буюу дунд шүлтлэг, нитратын азот 0.16%, хөдөлгөөнт фосфор 100 гр хөрсөнд 2.8 мг, кали 34 мг, солилцох Ca^{+2} , Mg^{+2} –ийн нийлбэр 19.0 мг-экв, **№ 2 дээжний** 0-20 үе давхаргад ялзмагийн агууламж 1.88%, хөрсний урвалын орчин pH 7.91 буюу сул шүлтлэг, нитратын азот 0.09%, хөдөлгөөнт фосфор 100 гр хөрсөнд 1.9 мг, кали 16 мг, солилцох Ca^{+2} , Mg^{+2} –ийн нийлбэр 14.2 мг-экв бол 20-40 үе давхаргад ялзмагийн агууламж 0.75%, хөрсний урвалын орчин pH 7.91 буюу сул шүлтлэг, нитратын азот 0.09%, хөдөлгөөнт фосфор 100 гр хөрсөнд 1.9 мг, кали 16 мг, солилцох Ca^{+2} , Mg^{+2} –ийн нийлбэр 14.2 мг-экв бол **№ 3 дээжний** 0-20 үе давхаргад ялзмагийн агууламж 1.81%, хөрсний урвалын орчин pH 8.21 буюу дунд шүлтлэг, нитратын азот 0.13%, хөдөлгөөнт фосфор 100 гр хөрсөнд 2.2 мг, кали 42.0 мг, солилцох Ca^{+2} , Mg^{+2} –ийн нийлбэр 15.6 мг-экв байна. **№ 4 дээжний** 0-20 үе давхаргад 1.55%, хөрсний урвалын орчин pH 7.81 сул шүлтлэг, нитратын азот 0.21%, хөдөлгөөнт фосфор 100 гр хөрсөнд 2.5 мг, кали 25 мг, солилцох Ca^{+2} , Mg^{+2} –ийн нийлбэр 19 мг-экв байгаа бол 20-40 үе давхаргад ялзмагийн агууламж 1.51%, хөрсний урвалын орчин pH 7.72 буюу сул шүлтлэг, нитратын азот 0.18%,

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

хөдөлгөөнт фосфор 100 гр хөрсөнд 2.3 мг, кали 20 мг, солилцох Ca^{+2} , Mg^{+2} –ийн нийлбэр 16.2 мг-эquiv байна. Харин № 5 дээжний 0-20 үе давхаргад ялзмагийн агууламж 1.22%, хөрсний урвалын орчин pH 7.94 буюу сул шүлтлэг, нитратын азот 0.11%, хөдөлгөөнт фосфор 100 гр хөрсөнд 2.2 мг, кали 34 мг, солилцох Ca^{+2} , Mg^{+2} –ийн нийлбэр 13.6 мг-эquiv тус тус гарчээ.

Карбонат дээрх 7 дээжний үе давхаргуудад огт илрээгүй нь карбонатгүй байгааг харуулж байна. Тус хөрсөнд ургамлын үндэсний биомасс харьцангуй сайн байна. Энэ үзүүлэлтээр үржил шимт давхаргын ялзмагийн нөөцийг №1-7 дээжний дунджаар нь тооцоолоход 41.6 тонн/га байна. Хөрсний цахилгаан дамжуулах чанар бүх дээжний дүнгээр (0.019-0.060) тооцоход тус газрын хөрс давсжилтгүй (0–2 dS m^{-1}) ангилалд багтана.

Хөрсний химийн үндсэн шинжийн үзүүлэлтүүд 2024.09 сар

№	Гүн, см	pH	Давс	ЦДЧ ds/m	Ялзмаг %	NO_3 , %	$CaCO_2$ %	Ca^{+2}	Mg^{+2}	P_2O_5 , мг/100г	K_2O , мг/100г
1	0-20	8.01	0.03	0.060	2.29	0.16	0.0	14.1	4.9	2.8	34
2	0-20	7.91	0.01	0.022	1.88	0.16	0.0	13.1	5.5	2.8	17
	20-40	7.91	0.01	0.020	0.75	0.09	0.0	9.1	5.1	1.9	16
3	0-20	8.21	0.01	0.039	1.81	0.13	0.0	9.2	6.4	2.2	42
4	0-20	7.81	0.01	0.019	1.55	0.21	0.0	12.1	6.9	2.5	25
	20-40	7.72	0.01	0.014	1.51	0.18	0.0	11.0	5.2	2.3	20
5	0-20	7.94	0.01	0.031	1.22	0.11	0.0	9.1	4.5	2.2	34

Солилцох сууриуд (Ca^{+2} , Mg^{+2})-ын нийлбэрт Ca^{+2} ион давамгайлах бөгөөд 7 дээжний үе давхаргад 13.6-19 мг-эquiv хооронд гарчээ.

Хөрсний механик бүрэлдэхүүн, % 2024.09 сар

Хөрсний хэв шинж	Зүсэлтийн дугаар	Гүн, см	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Цайвар хүрэн хөрс	1	0-20	22.6	52.8	6.7	6.1	8.6	3.0	17.8
	2	0-20	35.7	42.4	6.5	5.1	6.9	3.3	15.4
		20-40	29.0	55.5	0.7	5.7	6.5	2.6	14.8
	3	0-20	28.2	49.1	8.2	3.3	3.3	8.0	14.5
	4	0-20	31.1	42.2	7.8	7.0	7.3	4.6	18.9
		20-40	35.8	41.0	3.5	7.8	8.6	3.4	19.8
	5	0-20	33.7	49.8	3.0	3.5	3.7	6.3	13.6

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хөрсний өнгөн хэсэгт зарим хүнд металлуудын агууламжийг /MNS ISO 11466:2007/ атом шингээлтийн спектрометрээр шинжилж MNS 5850:2019 стандарттай харьцуулахад хром, хар тугалга, цайр, зэс, никель зэрэг хүнд металлуудын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна.

Хөрсөн дэх хүнд металлын агууламж 2024.09 сар

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хөрсөн дэх хүнд металлын агууламж, мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	0-20	7.16	ND	20.30	7.26	70.31	ND
3	0-20	9.20	ND	16.38	7.67	65.26	6.23
Хүлцэх агууламж/MNS 5850:2019/		150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
Хортой агууламж/MNS 5850:2019/		1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Аюултай агууламж/MNS 5850:2019/		1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт		/MNS 5850:2019/					

Харин хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх гэдэсний халдварт өвчин үүсгэгч эмгэг төрөгч бактери хөрсөнд байгаа эсэхийг тодорхойлох шаардлагагүй, эндхийн хөрс бохирдолгүй, цэвэр хөрс гэж үзсэн байна.

Хөрсний бохирдлын хяналт шинжилгээ, дээжлэлт /2025.10 сар/

Хөрсний хяналт шинжилгээний ажлын хүрээнд төслийн үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчид бохирдол үүсгэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор ШТС, Үйлдвэрийн цех, Уурхайн кемп гэсэн нийт 3 цэгээс хүнд металлын шинжилгээ, Шимт хөрсний овоолго орчмоос хөрсний агрохими, хөрсний механик бүрэлдэхүүн, Кемп орчмоос хөрсний эрүүл ахуй, микробиологийн шинжилгээний дээжүүдийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан мониторингийн цэгүүдээс авч Улаабаатар хот дахь итгэмжлэгдсэн лабораторид хийлгэсэн бөгөөд дээжийг авахдаа “MNS 3298:1991 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд” стандартыг баримталсан.

Хүснэгт 19. Хөрсний хяналт шинжилгээ хийгдсэн цэгүүдийн байршил

№	Шинжилгээний нэр	Байршил	Цэгийн координат	
			N	E
1	Хөрсний агорхими хөрсний механик бүрэлдэхүүн	Шимт хөрсний овоолго	108° 48' 57.436"	46° 6' 25.470"

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2	Хөрсний хүнд металын агууламж	ШТС	109° 15' 42.803"	46° 6' 47.904"
3	Хөрсний хүнд металын агууламж	Үйлдвэрийн цех	108° 48' 28.283"	46° 6' 3.763
4	Хөрсний хүнд металын агууламж	Кемп	108° 48' 3.212"	46° 6' 26.320"
5	Хөрсний эрүүл ахуй, микробиологи	Кемп	108° 48' 3.212"	46° 6' 26.320"

Зураг 16: Хөрсний шинжилгээний дээж авч буй үеийн зураг



Лабораторийн шинжилгээний үр дүн

Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хөрсний шинжилгээний лабораторид 2025 оны БОМТ-ны ОХШХ-т заагдсан 8 хүнд металлыг шинжлүүлсэн ба Монгол улсын “MNS5850:2019 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартад зөвшөөрөгдөх дээд хэмжээг зааж өгсөн байдаг. Доорх хүснэгтүүдэд лабораторийн шинжилгээний хариу дахь хүнд металлын агууламж болон MNS5850:2019 стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулан харуулав.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 20. Лабораторийн шинжилгээний дүн /хүнд металын агууламж/

Дээжний нэр	Дээж авсан гүн, см	Хөрсөн дэх хүнд металлын агууламж, мг/кг					
		Cr /Хром/	Cd /Кадми/	Ni /Никель/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cu /Зэс/
Кемп	0-20	38.5	-	28.6	30.1	78.9	47.6
Үйлдвэрийн цех	0-20	42.1	-	36.5	40.6	81.2	43.5
Овоолго	0-20	39.6	-	38.2	48.9	58.5	39.8
ШТС	0-20	37		39.9	47.9	67.9	44.7
Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 5850:2019/		100.0	1.5	100.0	70.0	150.0	100.0
Элсэнцэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 5850:2019/		60.0	1.0	60.0	50.0	100.0	60.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт		/MNS 5850:2019/					

Шинжилгээний үр дүнгээс харахад стандартад заагдсан 6 элемент бүгд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй агууламжтай байна.

Хүснэгт 21. Лабораторийн шинжилгээний дүн /хөрсний механик бүрэлдэхүүн/

Хөрсний хэв шинж	Дээжний нэр	Гүн, см	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Цайвар хүрэн хөрс	Кемп	0-20	8.5	34.0	32.0	10.1	7.3	8.1	25.5
	Үйлдвэрийн цех	0-20	8.6	39.6	26.0	9.5	9.3	7.0	25.8
	Овоолго	0-20	8.2	40.0	28.0	6.8	8.8	8.2	23.8
	ШТС	0-20	23.5	21.8	21.3	12.2	9.3	12.1	33.6

Хөрсний механик бүрэлдэхүүнийг олон улсын хэмжээнд мөрдөгддөг Гидрометрийн аргаар (элс, тоос, шаврын харьцаагаар) тодорхойлж, хөрсийг элсэнцэр гэж тогтоосон болно.

12.3. УСНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

Энэ бүс нутагт гадаргын усны жилийн дундаж нөөц 0.25 км³ байдаг нь нэн бага хэмжээ юм. Усны гадаргаас уурших ууршил 200 см/жил хүртэл байдаг бол ууршиц 80 см/жил-ээс их байна. Гадаргын усны болон хөрсний чийг багатай байдгаас уурших усны хэмжээ бага, харин уурших

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Боломжит хэмжээ манай орны хувьд хамгийн их байдаг нутаг юм. Гадаргын урсцын жилийн дундаж хэмжээ 1 мм орчим, гадаргын түр урсцын модуль 0.003 л/с.км², гадаргын жилийн нөөцийн хувийн нэгж 0.1 мян.м³/км² тус тус байна. Олон жилийн дундаж урсцын давхраа 25 мм-ээс бага, 1 хувийн хангамж бүхий шар ус, хур борооны үерийн хамгийн их урсцын модуль тус тус 0.1 м³ /с км-ээс бага, түр урсгал бүхий гол горхины муж байна. Бэлчээрийн болон унд ахуйн усны эх үүсвэр нь газрын доорх ус байх ба тус бүс нутагт сульфат зонхилсон эрдэсжилт ихтэй байдаг.

Усны хяналт шинжилгээний тухай

Усны хяналт шинжилгээний ажлын хүрээнд төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа уурхайн 1 гүний худаг болон нөлөөллийн бүсэд байгаа малчны 6 худгийг хамруулж усны хяналт шинжилгээний ажлыг 2025 оны 09 болон 10 дугаар сард хийж гүйцэтгэсэн ба боломжит 4 худгаас дээж авч, усны ерөнхий хими болон микро элементийн шинжилгээг УБ хотод байрлах байгаль орчны шинжилгээний лабораторид хийлгэсэн. Төслийн хамаарах нутгаар гадаргын ил урсац, байнгын урсацтай гол горхи, нуур цөөрөм байхгүй болно. Харин ойр хавийн уул толгодоос хөндий рүү чиглэсэн хуурай сайр, судгууд байх ба бороо хур ихтэй жил эдгээр сайруудад түр зуурын урсац үүсдэг байж болно. Энэ сайр, судгуудын дагууд нутгийн малчид худаг гаргасан байдаг.

Усны хяналт шинжилгээний ажлын үндсэн зорилго нь төслийн үйл ажиллагааны ажлын явцад газрын доорх усанд физик болон химийн нөлөөлөл үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, оролцогч талуудыг болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд оршино. Усанд үзүүлэх физик нөлөөлөлд усны түвшний мэдэгдэхүйц хэлбэлзэл хамаарах бол химийн нөлөөлөлд усны чанар найрлага өөрчлөгдөх, тухайн усны өнгө, үнэр, амтанд өөрчлөлт орох зэрэг үзүүлэлтүүд ордог.


Хүснэгт 20. Усны хяналт шинжилгээ хийгдсэн худгуудын байршил

№	Худгийн нэр	Мониторингийн цэгийн нэр	N	E
1	Уурхайн гүний худаг	WMP01	46° 7' 40.510"	109° 16' 59.029"

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2	Малчны худаг 1	WMP02	46° 07' 3.1"	108° 39' 29.9"
3	Малчны худаг 2	WMP03		
4	Малчны худаг 3	WMP04		

Зураг 17: Худгуудаас шинжилгээний дээж авч буй үеийн зураг



Шинжилгээний үр дүн

1. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа уурхайн гүний худгийн уснаас 2025 оны 9 дүгээр сард дээж авч Усны чанар рН, химийн шинжилгээ, усны ерөнхий шинжилгээ, микро-элементийн шинжилгээ, Усны чанар, Микробиологийн шинжилгээг 2025 оны 09 сарын 01-ээс 2025 оны 09 сарын 18-ны хооронд “Ханлаб” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлсэн бөгөөд шинжилгээний үр дүнгээр худгийн усны найрлагын хувьд дараах дүн гарсан.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 21. Уурхайн худгийн Усны чанар, микробиологийн шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжийн тодорхойлолт	Бактерийн ерөнхий тоо	Колиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян	Clostridium perfringens
1	Л-908	Ус	213	илрээгүй	илрээгүй	илрээгүй	илрээгүй
2	Шинжилгээний аргын стандарт		MNS ISO 6222:1998	MNS ISO 9308-1:1998	MNS ISO 9308-1:1998	MNS ISO 19250:2017	MNS ISO 6461-2:1998
3	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 0900:2018/		100	илрэхгүй 100 мл-д	илрэхгүй 100 мл-д	илрэхгүй 25 мл-д	илрэхгүй 100 мл-д

Микробиологийн шинжилгээний хувьд Колиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо, Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо, Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян, Clostridium perfringens үзүүлэлтүүд илрээгүй, харин 1мл усан дахь Бактерийн ерөнхий тооны зөвшөөрөгдөх дээд хэмжээ 100 байхаас 213 буюу давсан үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 22. Уурхайн худгийн химийн үзүүлэлтүүд, микро-элементийн шинжилгээний дүн

№	ЭЛЕМЕНТ	НЭГЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ /MNS 0900:2018/	СТАНДАРТ АРГА
1	pH	мг/л	8.06	6.5-8.5	MNS ISO 10523:2001
2	Кали (K)	мг/л	1.38	-	MNS 5465:2005
3	Натри (Na)	мг/л	74.02	200.0	MNS ISO 2572-1999
4	Кальци (Ca ²⁺)	мг/л	36.27	100.0	MNS ISO 7150-1:2006
5	Магни (Mg ²⁺)	мг/л	32.37	30.00	MNS ISO 9297:2005
6	Аммони (NH ₄)	мг/л	<0.10	1.50	MNS 3652.4:1984
7	Хлорид, (Cl)	мг/л	57.85	350.0	MNS ISO 11885:2011
8	Сульфат (SO ₄ ²⁻)	мг/л	86.80	500.0	MNS 4431:2005
9	Нитрит (NO ₂)	мг/л	<0.05	1.00	MNS ISO 7890-3:2001
10	Нитрат, (NO ₃)	мг/л	1.19	50.00	MNS ISO 9963-1:2005
11	Карбонат (CO ₃ ²⁻)	мг/л	10.50	-	MNS 4423:1997
12	Гидрокарбонат (HCO ₃ ²⁻)	мг/л	222.7	-	MNS 4343-1996
13	Нийт хатуулаг	мг-экв/л	4.47	7.00	MNS ISO 488:1999
14	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	440.0	1000	MNS ISO 6878:2001
15	Цахиурын хүчил, H ₂ SiO ₃	мг/л	23.01	-	MNS ISO 10359-1:2022
					MNS ISO 7393-1:2001
					MNS SO 11885:2011

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН “ДАЛАН УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ, ДАЛД АРГААР АШИГЛАХ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

16	Исэлдэх чадвар /KMnO ₄ /	мгO ₂ /л	1.60	-
17	Фосфат, PO ₄ ³⁻	мг/л	<0.05	3.5
18	Фтор, F	мг/л	2.82	0.7-1.5
19	Хүхэртустөрөгч, H ₂ S	мг/л	<0.10	0.1
20	Үлдэгдэл хлор, Cl _{res}	мг/л	<0.10	0.2-0.3
21	Булингар	NTU	<10	1.5
22	Мөнгө, Ag	мг/л	<0.01	0.1
23	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	0.50
24	Мишьяк, As	мг/л	<0.01	0.01
25	Бор, B	мг/л	0.17	2.40
 “УНДАРМАЛ ХҮДЭР” ХХК-ИЙН ИНЖЕНЕР: / Б.Мавсанзориг /
 ➤ ХУВИЙН ЗАРЦУУЛАЛТ: 0,54 кг/м³
 ➤ ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ОГНОО БА ЦАГ: 2025.10.12 18:30



ГҮЙЦЭТГЭЛ ГАРГАСАН:

“ТЕРА МАЙН” ХХК-ИЙН ТЭСЭЛГЭЭЧИН: / Риналтан /

ЦОНОГ ЦЭНЭГЛЭХ БҮТЦИЙН ЗУРАГ



ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН БЛОК СХЕМ



- Цэнэгийн гүн 70м
- Дундгийн диаметр 0.7м
- Бөмбөрцөгний диаметр 1.4м
- ТЭ-ийн гүн 1.5м (ТЭ-ийн диаметр 0.7м)
- Завсарын гүн ТЭ-ийн диаметр 0.7м
- Цэнэгийн гүн 1.4м
- Өдөөгчийн гүн 1.4м
- Роторын гүн 1.4м
- ТЭ-ийн гүн 1.4м (ТЭ-ийн диаметр 0.7м)
- Цэнэгийн гүн 1.4м
- ТЭ-ийн гүн 1.4м (ТЭ-ийн диаметр 0.7м)
- Цэнэгийн гүн 1.4м
- Өдөөгчийн гүн 1.4м

500 мегр
1 ат

ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ХИЙХ ҮЕИЙН АЮУЛГҮЙН ЗАЙГ ТОДОРХОЙЛОХ

➤ Тэсэлгээний үед бутлагдсан чулуулгийн шидэгдэх аюулгүйн зайг тодорхойлох:

Цооногийн цэнэгийн аргаар тэслэх үед бутлагдсан чулуулгийн хүнд аюулгүй байх зайг дараах томъёогоор тодорхойлов.

$$r_m = 1250 \cdot \eta_o \sqrt{\frac{f}{1 + \eta_m} \cdot \frac{d}{a}} = 1250 \cdot 0,58 \sqrt{\frac{60}{1+1} \cdot \frac{0,14}{3,5}} \cdot 325 = 400$$

$$\eta_o - \text{Цэнэг дүүргэлтийн коэффициент } \eta_o = \frac{L_u}{L} = \frac{35}{6} = 0,58$$

L_u - Цэнэгийн урт

L - Цооногийн гүн

η_m - Цооног дүүргэлтийн коэффициент дүүрэн түгжсэн үед нэгтэй тэнцүү

f - Чулуулгийн хатуулгийн коэффициент

d - Цооногийн диаметр $- 0,14$

a - Цооног хоорондын болон эгнээ хоорондын зай $a = 4 \quad b = 3,4$

➤ Тэсэлгээний үед үүсэх чичирхийллийн аюулгүйн зай

Бөөн цэнэгээр нэг удаа тэсэлгээ хийхэд газрын хөрсний доргилт барилга байгууламжид аюулгүй байх зайн тооцоо:

$$r_{a3} = \kappa_x \cdot \kappa_b \cdot \alpha \sqrt[3]{Q} =$$

κ_x - Байшин барилгын суурин дахь хөрсний хамаарлын илтгэлцүүр/ ан цавархаг өгөршсөн хөрсөнд $\kappa_x = 8$ -аар авна/

α - тэсэлгээний нөхцөл байдлаас хамаарах коэффициент, устай буюу ус нэвчсэн хөрсөнд цэнэгийг байрлуулсан бол коэффициентий утгыг 1,5-2 дахин өсгөж авна. $\alpha = 0,8 * 1,5 = 1,2$

κ_b - барилгын хийцээс хамаарах итгэлцүүр /металл-төмөр-бетон/ хийцтэй учраас $\kappa_b = 1$

Q - Цэнэгийн хэмжээ, нэг агшинд цооног тэсрэх ба кг болно

➤ Тэсэлгээс үүсэх агаарын цохих долгионоос байшин барилгад нөлөөлөх тооцоо

$$r_{a3} = k_o^1 \cdot \sqrt[3]{Q} = 30 \sqrt[3]{931} \approx 165 = 200 \text{ м стр}$$

k_o^1 - аюулгүйн зэрэг, үүсч болох гэмтэл, цэнэгийн жин, байрлалаас хамаарах пропорционалийн коэффициент, $k_o^1 = 20 - 50$

Тэсэлгээний ажлын үед мөрдөл болгох аюулгүйн бүсийн радиус:

- Хүнд 400 м

- Машин механизм 200 м байна.

ТЭСЭЛГЭЭНИЙ ХАРУУЛД ГАРАХ ХҮМҮҮСТ ӨГӨХ ЗААВАРЧИЛГААНЫ ХУУДАС

Тэсэлгээний ажил явуулах газар:

Уурхай : Бадан урам

Блок: R1 1312 202

Тувшин: 1312

Тэсэлгээний ажил хийгдэх огноо:

.....2025.10.12.....

Тэсэлгээний ажил хийгдэх цаг:

.....18:30.....

Цаг агаар	Нөхцөл	Тийм	Үгүй	Хариу арга хэмжээ
	Халуун			
Хүйтэн		✓		
Цас			✓	
Бороо			✓	
Шуурга			✓	
Уурхай н орчин	Нөхцөл	Тайлбар		
	Хальтаргаа		✓	
	Тоосжилт	✓		
	Замын нөхцөл		✓	

ТЭСЭЛГЭЭНИЙ ХАРУУЛЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА:

1. Тэсэлгээний өмнөх хуралд тэсэлгээ хийгдэхээс 60 минутын өмнө ирж суух.
2. Аюултай бүсийн зурагтай бүрэн танилцан тус тусын харуулын байршилээг мэдсэн байх.
3. Тэсэлгээний удирдагчаас аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан байх.
4. Тэсэлгээний ажлын өмнөх 30 минутын анхааруулга зарлахад бүх харуулууд тус тусын байрлалаа эзлэж аюултай бүс рүү чиглэсэн бүх хөдөлгөөнийг хорих. Радио станцыг сонсох горимд байлгах.
5. Тэсэлгээний ажлын өмнөх 10 минутын анхааруулга зарлахад харуулууд тайван байдлыг илтгэн мэдээ өгөх.
6. Тэсэлгээний ажлын өмнөх 2 минутын анхааруулга зарлана.
7. Тэсэлгээ хийгдэхээс өмнөх 10 сек тоолсноор тэсэлгээний ажил хийгдэнэ.
8. Тэсэлгээний удирдагчийн зааврын дагуу тэсэлгээний ажил хийгдэж дуусвал харуулууд байрлалаа орхихгүй байх.

ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮЕД ХАРУУЛЫН ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД АВАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ:

1. Тэсэлгээний харуул байрлал зөрчсөн.
2. Тэсэлгээний аюултай бүс рүү тэсэлгээний багаас бусад хүн техник нэвтэрсэн.
3. Аюултай бүс дотор хэн нэгэн байгааг илрүүлэх.

Дээрхи тохиолдолд тэсэлгээний удирдагчид яаралтай мэдэгдэн тэсэлгээний ажлыг хойшлуулах хүртэл арга хэмжээ авна.

№	МАШИНЫ ТӨРӨЛ	ХАРУУЛЫН НЭРС	ГАРЫН ҮСЭГ	УТАСНЫ ДУГААР
ХАРУУЛ 1	Land 200	Зикбадрах		8888 6702
ХАРУУЛ 2	Lexus 600	Зиксүрэг		8902 2776
ХАРУУЛ 3	Jimmy	Б.Лувсансүрэн	<i>[Signature]</i>	9511 9544
ХАРУУЛ 4	Саарал флекси	Анхирсүрэн		9903 4805
ХАРУУЛ 5	tundra	Мэвсүрэн		8809 8464
ХАРУУЛ 6				
ХАРУУЛ 7				
ХАРУУЛ 8				

ЗААВАРЧИЛГАА ӨГСӨН:

"ТЕРА МАЙН" ХХК-ИЙН ТЭСЭЛГЭЭНИЙ ИНЖЕНЕР:*Ламияашир*.....

ХАРУУЛЫН ХЯНАГЧ:

УУРХАЙН МАСТЕР:*Лувсансүрэн*.....

ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН БЛОК ХҮЛЭЭЛЦЭХ АКТ № 25/...02

2025 оны 10 сарын 12 дрийн

13.12 Түвшингүрс дараа хуурай

алуулсан блокгоз тэслэгээний амил

хэвсгийг дасан тул

тэслэгдсэн блок хүлээн авлаа.

1. Баарсан цэнэг байгаа эсэх, чанарын дүгнэлт

байр гүб

2. Цаашид авах арга хэмжээ

дараа тэслэгээний гол үрэгтэ

амил хүлээн авсан байх
боловсон үзүүлэлт хамгаалах

3. Тэслэгдсэн уулын цулын хэмжээ: 31.900 м³

4. Зарцуулсан тэсрэх бодисын хэмжээ 0.54 кг

Тэслэгдсэн блокыг хүлээлгэн өгсөн:

“ТЕРА МАЙН” ХХК-ийн

Тэслэгээний удирдагч:

Тэслэгээчин:

Тэслэгдсэн блокыг хүлээн авсан:

“Ундармал хүдэр” ХХКомпанийн

Төслийн менежер:

2025 оны 10-р сарын 12-ний өдөр



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000278761

2016.05.03

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011604121

/ Хувийн хэргийн дугаар /

6072402

/ Регистрийн дугаар /

Ундармал хүдэр

Хязгаарлагдмал хариуцлагатай
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

1

/ дугаар /

2016.04.26

/ он, сар, өдөр /

7210
4653
8299
46100
08990

/ Код /

Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх
Уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа, засвар үйлчилгээ
Бизнесийн зөвлөгөө өгөх
Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
Ашигт малтмал хайх /2022.04.04-2025.04.04/

/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

2

/ гишүүдийн тоо /

20.00

/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 17-р хороо, тайм сүүэр, 506, 1201 тоот, Утас1: 99113123, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

/ Егүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ
/ тэмдэг /

УЛСЫН
БҮРТГЭГЧ
/ тэмдэг /

БАЛАНСҮХ
/ гарын үсэг /

Гэрчилгээ дахин олгосон 2023 он 05 сар 18 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн:	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Энхбаатар овогтой Содболд-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2022.06.09	Н.Золжаргал
2	Дахин гэрчилгээ олгов.	2023.05.18	Б.Алтансүх
3	Цогтхүү овогтой Энхбадрах-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2024.05.06	Д.Батцэцэг
4	Хувьцаа эзэмшигч 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2024.07.18	Н.Золжаргал
5	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2024.07.18	Н.Золжаргал 572



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000278761



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар *MV-022826*

Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Дорноговь аймаг /хот/-ийн

Даланжаргалан сум /дүүрэг/-ын

Далан ухаа нэртэй газарт орших

1422.95 гектар талбай бүхий уурхайн талбайд

хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 9011604121 тоот гэрчилгээтэй

“Ундармал хүдэр” ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 2054.10.14 дуусгал

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

М.ЭНХТУЛГА

2024 оны 10 дугаар сарын 14 ний өдөр

Улаанбаатар хот



0000759



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-022826

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
001-NM	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2024.10.14, дуусах хугацааТусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөвКадастрын хэлтсийн даргын 2024.10.08-ний 454 тоот шийдвэр	
002-FE	<ul style="list-style-type: none">Баталсан: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2025.10.14 – 2026.10.14 хүртэл	



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

MV-022826

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг			
				#	Уртраг	Өргөрөг	
001-NM	<ul style="list-style-type: none">Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2024.10.14	1422.95 Га	0 Га	1	108° 47' 21.62"	46° 4' 27.66"	
				2	108° 47' 21.63"	46° 5' 31.66"	
				3	108° 47' 58.63"	46° 5' 31.66"	
				4	108° 47' 58.63"	46° 7' 3.65"	
				5	108° 50' 1"	46° 7' 3.65"	
				6	108° 50' 1"	46° 4' 27.66"	

2024.10.14 Д.Мягмарсүрэн





**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар Т/16

Улаанбаатар хот

Техник, эдийн засгийн үндэслэл
бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Т/24-27-05 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Ундармал хүдэр” ХХК-ийн MV-022826 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Далан-Ухаа” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил, далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг бүртгэсүгэй.

2. Бүртгэсэн техник, эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхайн хэлтэс (Т.Зууннаст)-т даалгасугай.

3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулахад хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн хэлтэс (Т.Зууннаст)-т даалгасугай.

4. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн хэлтэс (Т.Зууннаст)-т даалгасугай.

5. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Ундармал хүдэр” ХХК-ийн MV-022826 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Далан-Ухаа” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил, далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хуулсан дискийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хүлээн авахыг Уул уурхайн хэлтэс (Т.Зууннаст)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ГАНХУЯГ



1525100109



АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар Т/24-24-05

Улаанбаатар хот

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших MV-022826 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Далан-Ухаа” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил, далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн тухай

“Ундармал хүдэр” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Лордмайн прожект” ХХК-ийн боловсруулсан Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Далан-Ухаа” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил, далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлд Монгол Улсын зөвлөх инженер Н.Даваасамбуу зөвлөж, Монгол Улсын зөвлөх инженер Ч.Болдбаатар шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

2. Техник, эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулах, үйлдвэрлэл явуулах бүх шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үндсэн баримт бичиг болжээ.

3. Техник, эдийн засгийн үндэслэл нь Төслийн танилцуулга, Ерөнхий мэдээлэл, Ил уурхайн олборлолт, Далд уурхайн техник, технологи олборлолт, Баяжуулах технологи, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, Уурхайн эдийн засаг, төсөв санхүү гэсэн 9 бүлэг, дүгнэлт, хавсралт материал бүхий 294 хуудас тайлбар бичиг, 37 хавсралт зургуудаас бүрдэж байна.

4. “Далан-Ухаа” нэртэй төмрийн хүдрийн ордын MV-022826 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хурлын ХХ-01-03 тоот дүгнэлт, Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн н/20 тоот тушаалаар

исэлдсэн хүдрийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 25.41%-ийн дундаж агуулгатай 30.26 мян.тн хүдэрт 7.69 мян.тн төмөр, боломжтой (С) зэрэглэлээр 30.33%-ийн дундаж агуулгатай 225.95 мян.тн хүдэрт 68.52 мян.тн төмөр, бодитой ба боломжтой (В+С) зэрэглэлээр 29.75%-ийн дундаж агуулгатай 256.20 мян.тн хүдэрт 76.21 мян.тн төмөр, анхдагч хүдрийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 30.24%-ийн дундаж агуулгатай 31.00 мян.тн хүдэрт 9.37 мян.тн төмөр, боломжтой (С) зэрэглэлээр 31.73%-ийн дундаж агуулгатай 397.85 мян.тн хүдэрт 126.25 мян.тн төмөр, бодитой ба боломжтой (В+С) зэрэглэлээр 31.63%-ийн дундаж агуулгатай 428.85 мян.тн хүдэрт 135.63 мян.тн төмөр, ордын нийт исэлдсэн ба анхдагч хүдрийн нөөцийг бодитой ба боломжтой (В+С) зэрэглэлээр 29.43%-ийн дундаж агуулгатай 685.05 мян.тн хүдэрт 211.84 мян.тн төмөр гэж ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэжээ.

5. Төсөлд ил уурхайн ашиглалтын үеийн бохирдол 1.45% буюу 5.26 мян.тн, хаягдал 3.31% буюу 12.44 мян.тн байхаар тооцож геологийн бодитой ба боломжтой (В+С) зэрэглэлийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нийт 369.01 мян.тн хүдэр, хүдэр дэх металлын хэмжээ 111.76 мян.тн байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 907.95 мян.м³ хөрс хуулалт хийхээр тооцжээ. Ил уурхай жилд 200.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар 2 жилийн хугацаанд ажиллахаар төлөвлөжээ.

Далд уурхайн ашиглалтын үеийн бохирдол 5.96% буюу 13.31 мян.тн, хаягдал 11.64% буюу 29.40 мян.тн байхаар тооцож геологийн бодитой ба боломжтой (В+С) зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нийт 236.53 мян.тн хүдэр, хүдэр дэх металлын хэмжээ 69.91 мян.тн байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 644 м үндсэн малталт, 1813 м бэлтгэл малталт нэвтрэхээр тооцжээ. Жилд 150.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар 2 жилийн хугацаанд ажиллахаар төлөвлөжээ.

6. Ил уурхайн ашиглалтын систем нь авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын систем, далд уурхайн ашиглалтын систем нь хоршоолон нураах ашиглалтын системээр тус тус ашиглахаар төлөвлөжээ.

7. Ил уурхайн хөрс хуулалтын ажилд 3 м³-ийн утгуурын багтаамжтай HITACHI PC600-8 маркийн экскаватор 1, хүдэр олборлолтын ажилд 1.5 м³-ийн утгуурын багтаамжтай HITACHI PC300-8 маркийн экскаватор 1, хөрс хуулалтын ажилд 63 тн даацтай KONATSU HD605-7 маркийн автосамосвал 2, хүдэр олборлолтын ажилд 45 тн даацтай KONATSU HD405-6 маркийн автосамосвал 1, өрөмдлөг тэсэлгээний ажилд 150 мм-ийн диаметртэй ROC-L8 маркийн өрмийн машин 1, хөрсний овоолго түрэх ажилд 3 м³-ийн утгуурын багтаамжтай SDLG-933 маркийн утгуурт ачигч 1, CATERPILLAR фирмийн D8 маркийн бульдозер 1 зэрэг тоног төхөөрөмжүүдийг үндсэн процессуудад ашиглахаар сонгон тооцоолжээ.

Далд уурхайд 45 мм диаметр бүхий өрмийн хошуутай HFG-19J маркийн өрмийн машин 1 ш, 42 мм диаметр бүхий өрмийн хошуутай YT-28 маркийн гар өрмийн машин 2, 1.3 м³ утгуурын багтаамжтай SANDVIK LH202 маркийн утгуурт ачигч 1, 15 тн SANDVIK TH315 маркийн автосамосвал 1, 2ц-2.5x1.2 маркийн өргөх төхөөрөмж 3, 0.32 м³-ийн утгуурын багтаамжтай Z17-AW утгуурт ачигч 1, S100D маркийн компрессор 3, ВОД-11П маркийн агааржуулалтын суурин сэнс 1, ВМЭ-6 маркийн агааржуулалтын зөөврийн сэнс 2, ЦНС-13-105 маркийн усны шахуурга 2, DZD-25 маркийн усны шахуурга 2 зэрэг тоног төхөөрөмжүүдийг үндсэн процессуудад ашиглахаар сонгон тооцоолжээ.

8. Баяжуулах хэсгийн технологийг “Ундармал хүдэр” ХХК-аас өгсөн техникийн даалгавар болон “Тру ти ар си” ХХК-д гүйцэтгэсэн туршилтын тайлангийн үр дүнд үндэслэн сонгосон байна. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал 200.0 мян.тн/жил байна. Уг ордын хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулан 51%-ийн агуулгатай, 76.71% металл

авалттай, 45.78%-ийн гарцтай, 277.25 мян.тн төмрийн баяжмал болон 40%-ийн агуулгатай, 9.0%-ийн металл авалттай, 6.8%-ийн гарцтай, 41.5 мян.тн завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр тооцсон байна.

9. Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг Чойр-Сайншандын 110 кВ-ын шугамаас орд хүртэл 10 кВ-ын шугам татаж төвлөрсөн цахилгаан түгээх шугам сүлжээнээс эрчим хүчээр хангахаар төсөлд тусгажээ. Ажиллагсдын унд ахуйн усны хэрэгцээнд жилд дунджаар 3.5 мян.м³, уурхайн технологийн усны хэрэглээнд жилд дунджаар 5.93 мян.м³, далд уурхайн технологийн усны хэрэглээнд жилд дунджаар 1.53 мян.м³, бусад хэрэгцээнд жилд дунджаар 0.88 мян.м³ ус хэрэглэхээр төлөвлөжээ. Энэхүү усан хангамжийн хэрэгцээг шинээр гүний худаг гарган хангахаар тооцоолжээ. 51% агуулгатай төмрийн баяжмалыг авто машин болон төмөр замаар тээвэрлэн БНХАУ-д экспортлох ба завсрын бүтээгдэхүүнийг дотоодын нойтон баяжуулах үйлдвэрүүдэд борлуулна.

10. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 583.82 сая төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчны хяналт шинжилгээнд 7.0 сая төгрөг, байгаль орчин хамгаалах арга хэмжээнд 87.2 сая төгрөг, дүйцүүлэн хамгаалах ажилд 40.0 сая төгрөг, нөхөн сэргээлтийн нийт зардалд 174.5 сая төгрөг, үүнээс нөхөн сэргээлтийн бэлтгэл ажилд 21.05 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 42.87 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 87.59 сая төгрөг, хаалт мониторингийн зардалд 249.13 сая төгрөг, Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 26.0 сая төгрөг тус тус зарцуулахаар төсөлд тусгажээ.

11. Уг төслийг хэрэгжүүлснээр нийт 104 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 2.6 сая төгрөг байна.

12. Төсөл хэрэгжүүлэхэд нийт 9.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс үндсэн малталт нэвтрэлтийн ажилд 2,183.2 тэрбум төгрөг, биет бус хөрөнгө оруулалт 1,209.5 сая төгрөг, эргэлтийн хөрөнгө 500.0 сая төгрөг, далд уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдэд 1,372.0 сая төгрөг, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 2,021.8 сая төгрөг, туслах машин техникүүдэд 1,094.5 сая төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 1,425.0 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардалд нийт 856.1 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

13. Уурхайг ашиглах хугацаанд нийт /НӨАТ нэмэгдсэн дүнгээр/ 47.45 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл үйл ажиллагааны зардал гарган, 63.02 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 15.56 тэрбум төгрөгийн татварын өмнөх, татвар ногдуулсны дараах байдлаар нийт 13.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 10.56 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд 1 тн баяжмалын бүрэн өөрийн өртөг 161.63-179.8 мян.төг/тн байна.

14. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 17.03 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 4.26 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 34 %, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1.4 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник, эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна. Үүнд:

1. Төсөл захиалагч Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажиллах;

2. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах;
3. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
4. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн Лордмайн прожект ХХК, мөн ТЭЗҮ-ийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын зөвлөх инженер Ч.Болдбаатар тус тус хариуцах.

Техник, эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших MV-022826 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Далан-Ухаа” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил, далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг бүртгэн авах;
2. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголд дахин тодотгол хийлгэж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших MV-022826 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Далан-Ухаа” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил, далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, түүнийг хуулсан диск, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн ажлын 5 өдөрт багтаан хүлээлгэн өгөх арга хэмжээг авах;

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.САГАРААДОРЖ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ц.ӨНӨРНАСАН

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ХУЛАН

Т/24-27-05

Дорноговь аймгийн Даланжаргалайдвэрлэлийн нөөцийн тооцоо

№	Батлагдсан нөөц						Ил уурхайн хүрээнд дэх үйлдвэрлэлийн нөөц					
	Ашиглалтын түвшин М	Хүдрийн нөөц мян.тн	Дундаж агуулга %	Металлын нөөц тн	Хүдрийн нөөц мян.тн	Дундаж агуулга %	Дундаж агуулга мян.тн	Дундаж агуулга %	Металлын нөөц тн	Хөрс хуулалт мян.м ³	Хөрс хуулалтын итгэлцүүр м ³ /м ³	Хөрс хуулалтын итгэлцүүр м ³ /тн
1	Исэлдсэн хүдэр В						Исэлдсэн хүдэр В'					
2	1328 -> 1336				0.23	35.71	0.23	35.00	81	1.00	16.49	4.33
3	1320 -> 1328	0.30	25.41	77	28.30	31.79	28.29	31.18	8821	89.50	12.05	3.16
4	1312 -> 1320	6.91	25.41	1757	68.62	30.75	72.73	29.94	21778	232.50	12.18	3.20
5	1304 -> 1312	8.04	25.41	2043	72.46	29.98	79.12	29.15	23069	250.00	12.04	3.16
6	1296 -> 1304	8.42	25.41	2139	46.93	29.33	52.05	28.31	14734	132.00	9.66	2.54
7	1288 -> 1296	6.58	25.41	1673	9.19	30.07	6.81	24.00	1635	15.00	8.39	2.20
8	1280 -> 1288				0.21	40.77						
9	Нийт	30.26	25.41	7688	225.95	30.33	239.24	29.31	70118	720.00	11.47	3.01
10	Анхдагч хүдэр В						Анхдагч хүдэр В'					
11	1304 -> 1312				2.55	36.88	2.50	36.4	911	2.00	3.18	0.80
12	1296 -> 1304				16.16	33.40	15.93	32.9	5235	33.00	8.24	2.07
13	1288 -> 1296	2.17	30.24	657	50.75	31.09	37.82	31.5	11911	60.00	6.31	1.59
14	1280 -> 1288	10.98	30.24	3321	64.50	30.99	29.10	31.3	9114	45.00	6.15	1.55
15	1272 -> 1280	9.03	30.24	2732	73.89	31.83	18.98	33.0	6256	35.00	7.34	1.84
16	1264 -> 1272	5.86	30.24	1771	83.12	31.77	24.56	32.3	7946	12.50	2.03	0.51
17	1256 -> 1264	2.42	30.24	733	48.56	31.19	0.87	30.8	269	0.45	2.05	0.51
18	1248 -> 1256	0.52	30.24	158	25.43	32.93						
19	1240 -> 1248	0.01	30.24	3	15.03	33.62						
20	1232 -> 1240				6.32	34.10						
21	1224 -> 1232				3.61	30.31						
22	1216 -> 1224				5.05	30.49						
23	1208 -> 1216				2.62	30.49						
24	1200 -> 1208				0.25	30.49						
25	Нийт	31.00	30.24	9375	397.85	31.73	129.77	32.09	41642	187.95	5.76	1.45
26	Нийт исэлдсэн ба анхдагч	61.26	27.9	17063	623.79	31.22	369.01	30.29	111760	907.95	9.52	2.46

№	Ил уурхайн хүрээний гаднах нөөц			Далд уурхайн х			Үйлдвэрлэлийн нөөцийн зэрэг, дугаар	Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо			
	Хүдрийн биетийн блокын дугаар	Хүдрийн нөөц мян.тн	Дундаж агуулга %	Металлын нөөц тн	Хүдрийн нөөц мян.тн	Дундаж агуулга %		Хүдрийн нөөц мян.м ³	Дундаж агуулга мян.тн	Металлын нөөц %	Металлын нөөц мян.тн
1	В-1	6.1	25.41	1.55			В'-101	11.75	46.53	30.89	14.37
2	С-23	5.71	26.66	2.08	5.28	37.16	В'-102	4.26	16.97	32.19	5.46
3	Нийт	11.81	30.71	3.63	5.28	37.16	В'-103	4.93	19.83	32.63	6.4
							В'-104	3.72	14.82	26.91	3.99
4	В-1	31	30.24	9.37			В'-105	3.99	15.89	26.91	4.27
5	С-24	24.99	35.22	8.8	3.07	35.22					
6	С-20	22.18	32.84	7.28			В'-106	3.44	13.69	26.91	3.68
7	С-12	21.72	33.68	7.32							
8	С-36	42.95	29.2	12.54			В'-107	1.03	4.12	25.42	1.05
9	С-37	11.06	28.88	3.2							
10	С-40	24.91	28.71	7.15			В'-108	1.96	7.79	25.42	1.98
11	С-41	20.56	25.78	5.3							
12	С-33	49.79	35.44	17.65			В'-109	2.09	8.31	26.09	2.17
13	С-3	1.17	36.01	0.42	1.17	36.01					
14	С-4	3.82	31.01	1.18	3.82	31.01	В'-110	2.41	9.57	26.09	2.5
15	С-5	2.84	30.4	0.86	2.84	30.4					
16	С-6	3.31	24.6	0.81	3.31	24.6	В'-111	2.03	8.08	26.09	2.11
17	С-7	1.09	27.73	0.3	1.09	27.73					
18	С-8	11.81	30.49	3.6	11.81	30.49	В'-112	1.62	6.45	24.27	1.57
19	С-10	0.48	27.06	0.13	0.48	27.06					
20	С-13	0.03	39.38	0.001	0.03	39.38	В'-113	1.88	7.47	24.27	1.81
21	С-17	0.02	32.22	0.001	0.02	32.22					
22	С-34	6.96	29.71	2.07	6.96	29.71	В'-114	1.56	6.23	24.27	1.51
23	С-35	5.81	31.25	1.82	5.81	31.25					
24	С-38	10.54	26.57	2.8	10.54	26.57	В'-115	6.5	25.87	33.41	8.64
25	Нийт	297.04	31.18	92.63	50.94	29.64	В'-116	6.31	25.13	33.41	8.4
26	Нийт исэлдсэн ба анхдагч	308.9	31.17	96.26	56.22	30.34	Нийт	59.49	236.53	29.56	69.91

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших MV-022826 тоот ашигхүлээн авч, УГА-ны даргын 2024 оны 05 дугаар сарын 10 -ны өдрийн Н-20 тоот тушаалаар Исэлдсэн хүдрийн бодитой (В) зэргээр 30.256 мян.тн хүдэр, хүр 256.202 мян.тн, хүдэр дэх металлын хэмжээ 76207.6 тн (дундаж агуулга 29.75%), анхдагч хүдрийн бодитой (В) зэргээр 31.00 мян.тн хүдэр, хүдэр дэх 128.847 мян.тн, хүдэр дэх металлын хэмжээ 135628.97 тн (дундаж агуулга 31.63%) тус тус хүлээн авч бүртгэсэн. Тус орд нь III бүлэгт хамаарах тус бодитологийн бодитой (В) болон боломжтой (С) зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцов. Тус ордыг ил ба далд уурхайн аргаарна. Ил уурхайн хүрээнд бодитой ба боломжтой (В+С) зэргээр 376.2 мян.тн хүдэр, хүдэр дэх металлын хэмжээ 115581.5 тн (дундаж агуулга 30.72%) нөөц з' зэргээр 369.01 мян.тн, хүдэр дэх металлын хэмжээ 111759.9 тн (дундаж агуулга 30.3 %) байна. Далд уурхайн хүрээний гадна бодитой ба боломжтой (Б252.63 мян.тн, хүдэр дэх металлын хэмжээ (дундаж агуулга 31.35 %) нөөц багтаж байна. Олборлолтын үеийн хаягдал, бохирдолыг ашиглалтын блок тус (56 %) байна

Танилцсан: АМГТГ-ын УУХ-ийн металл ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, 6 хариуцсан мэргэжилтэн: Д.Мөнх

Handwritten signature and date: 2024-12-19.

Нөөцийн тооцоог хийсэн: "Лордмайн прожект" ХХК-ийн уулын инженер Н.Пүрэвдаш





ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 4/20

Улаанбаатар хот

Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн ХХ-01-03 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Далан ухаа нэртэй XV-022087 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамаарах Далан-Ухаагийн төмрийн хүдрийн ордод 2022-2023 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан (Ордын нөөц 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар) дахь исэлдсэн хүдрийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 25.41%-ийн дундаж агуулгатай 30,256.58 тн хүдэрт 7,688.2 тн төмөр, боломжтой (С) зэрэглэлээр 30.33%-ийн дундаж агуулгатай 225,945.8 тн хүдэрт 68,519.4 тн төмөр, нийт исэлдсэн хүдрийн нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 29.75%-ийн дундаж агуулгатай 256,202.38 тн хүдэрт 76,207.6 тн төмөр, анхдагч хүдрийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 30.24%-ийн дундаж агуулгатай 31,000.82 тн хүдэрт 9,374.65 тн төмөр, боломжтой (С) зэрэглэлээр 31.73%-ийн дундаж агуулгатай 397,846.42 тн хүдэрт 126,254.32 тн төмөр, нийт анхдагч хүдрийн нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 31.63%-ийн дундаж агуулгатай 428,847.24 тн хүдэрт 135,628.97 тн төмөр, ордын нийт исэлдсэн ба анхдагч хүдрийн нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 29.43%-ийн дундаж агуулгатай 685,049.62 тн хүдэрт 211,836.57 тн төмрөөр хүлээн авсугай.

2. Хүлээн авсан геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Гео-мэдээллийн төв (Ц.Минжинсор)-д зөвшөөрсүгэй.

3. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Далан ухаа нэртэй XV-022087 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамаарах Далан-Ухаагийн төмрийн хүдрийн ордод 2022-2023 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг бичвэр дискийн хамт Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдааны дүгнэлт, түүний дагуу гаргасан Үндэсний Геологийн Албаны даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг "Ундармал хүдэр" ХХК (Э.Содболд)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.МӨНХТӨР

182801 00132



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2024 оны 02 дугаар сарын 22

№ ХХ-01-03

Улаанбаатар хот

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Далан-Ухаа төмрийн хүдрийн ордод 2022-2023 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Далан-Ухаа төмрийн хүдрийн ордод 2022-2023 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр Монгол Улсын мэргэшсэн геологич С.Мөнхбаяр, геологич А.Лхагвасүрэн, Н.Наран-Эрдэнэ, Б.Амгаланбаатар, Б.Даваадорж, Н.Ядмаа нарын боловсруулсан тайлан, уг тайлан дахь төмрийн хүдрийн ордын нөөцийн тооцоонд Монгол Улсын зөвлөх геологич Б.Алтангэрэл шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна. Үүнд:

1. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Далан-ухаа” нэртэй 6,205.15 га талбай бүхий XV-022087 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр АМГТГ-ын, ГУУК-ын хэлтсийн даргын 161 тоот шийдвэрээр анх олгосон байна.

Далан-Ухаа төмрийн хүдрийн орд нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт Даланжаргалан сумын төвөөс зүүн хойш 28 км, Өлзийт өртөөнөөс зүүн хойш 8.1 км, УБТЗ-ын 25-р зөрлөгөөс зүүн хойш 32км, Улаанбаатар хотоос зүүн урагш 270км, Говь-Сүмбэр аймгийн төв Чойр хотоос зүүн урагш 55км зайд байрладаг.

2. “Ундармал хүдэр” ХХК нь Далан-Ухаа төмрийн хүдрийн ордод 2022-2023 онд геологи, хайгуулын ажлыг гүйцэтгэж, ордын нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр тогтоож, хайгуулын ажилд нийт 1,004.5 сая төгрөг зарцуулсан байна.

3. 1953-1954 онуудад А.Н.Ефимов, З.А.Кузнецова нар Чойрын районд 1:20000-ны масштабтай геологийн зураглалын ажил (№612), 1967 онд В.И.Блюменцвайг, А.И.Попов нар Төв Монголд 1:200'000 масштабтай агаарын соронзон зураглалын ажил (№1730), 1986-1988 онуудад А.Батхүү, Н.Ягаан нар 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар шохойн чулууны илрэл тогтоосон.

4. “Ундармал хүдэр” ХХК нь хайгуулын талбайн хэмжээнд 218 ш ховилон дээжлэлт, 12 хайгуулын шугамын дагуу 12 ш 673.66 м³ суваг малгалт, 627 ш чөмгөн дээжлэлт хийсэн. 23 хайгуулын шугамд 40 м зайтайгаар 39 цооногт 2,950 т.метр баганат өрөмдлөгийн ажлыг “Агшай зоос” ХХК, “Монгоулд дриллинг” ХХК-иар, 1:5000-ны масштабтай зураглалын ажлыг “Азар Мэргэд” ХХК-ийн геологич Б.Лувсандагва, П.Ариунболд нар, хээрийн судалгаа цооног, суваг төлөвлөлтийн ажлыг “Ундармал хүдэр” ХХК-ны геологич Б.Энхтайван, 1:2000-ны масштабтай байр зүйн зураглалын ажлыг “Мэжор сүрвэй” ХХК, технологийн туршилт 2ш дээжинд, 44 элементийн шинжилгээ 230ш дээжинд, химийн

шинжилгээг 234ш дээжинд, гадаад хяналтанд 22ш дээжийг “Трү Ти Ар Си” ХХК, “Эс Жи Эс-Ай Эм Эм И Монголиа” ХХК итгэмжлэгдсэн лабораторид, палеонтологийн судалгааны ажлыг ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Д.Доржнамжаа, ЭШ-ний ажилтан Б.Энхбаатар, Д.Идэрсайхан нар, Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг Монгол Улсын Их Сургуулийн Антропологи, Археологийн тэнхимийн профессор З.Батсайхан, эрдэм шинжилгээний ажилтан А.Золжаргал нар, геофизикийн судалгааны ажлыг “Азармэргэд”, “Аячук” ХХК, суурин боловсруулалт, дээжлэлтийг “Эм Эн Эн Си” ХХК, чулуулгийн физик механик шинж чанарын дэлгэрэнгүй судалгааг “Трү Ти Ар Си” ХХК, гамма спектрометрийн шинжилгээг МУИС-ийн харьяа цөмийн физикийн судалгааны төв, төмрийн фазын шинжилгээг “Ханлаб” ХХК, чулуулаг ба хүдрийн петрографи, минераграфийн бүрэн бичиглэлийг ШУТИС-ийн ГУУС-ийн профессор, МУ-ын зөвлөх инженер С.Оюунгэрэл нар тус тус гүйцэтгүүлсэн байна.

5. Далан-Ухаа төмрийн хүдрийн орд нь геологийн тогтцын хувьд дунд девоны Давхар уул формацийн (D₂du) цагаан, цагаан саарал өнгийн гантигжсан шохойн чулуу, Бор-Өндөр бүрдлийн жижиг-дунд ширхэгтэй гранитын хил заагт үүссэн магнилаг скарн төрлийн орд юм. Хүдэр агуулагч шохойн чулуу нь катаклазжиж, цул цахиуржсан, катакласт структуртай, 0.01-1.05мм мөхлөгийн хэмжээтэй, үеллэг текстуртай. Хүдрийн голлох эрдэс нь 47.5-76.5% төмөр агуулсан магнетитаас голлох ба пирит, халькопирит, гематит, пирротин, тенорит эрдсээс тогтоно. Хүдрийн эрдсийн ялгарлын дараалал нь магнетит-гематит-пирит-пирротин-халькопирит-арсенопирит-тенорит байна.

6. Далан-Ухаа ордын төмрийн хүдрийн бутлалтын үеийн хатуулаг исэлдсэн хүдрийн хувьд зөөлөн, анхдагч хүдрийн хувьд дунд ангилалд багтана. Гүйцээн баяжуулах схемийн туршилтын үр дүнгээр соронзон орны 880 ГС үзүүлэлттэй, 3 шатны цэвэрлэгээтэй хуурай соронзон ялгалтаар исэлдсэн хүдрийн агуулга 58.39 %, гарц 17.22 %, металл авалт 31.96 %, анхдагч хүдрийн хувьд агуулга 53.05 %, гарц 55.29 %, металл авалт 79.57 % баяжмал гарган авах боломжтой нь туршилтаар тогтоожээ.

7. Зохиогчид ордын ойролцоо байрлалтай Баргилт, Хар төмөртэй, Майхан толгой, Дөрвөлжин, Өлзийт-Ухаа төмрийн хүдрийн олборлолт явуулж байгаа ордуудын жишиг үзүүлэлтүүдийг үндэс болгон дараах жишиг үзүүлэлтүүдийг сонгон авсан байна. Үүнд:

- Хүдрийн биетийг хязгаарлах захын агуулга -20%
- Нөөцийн хэсэглэлийн үйлдвэрлэлийн хамгийн бага агуулга -25%
- Хүдрийн биетийн хамгийн бага зузаан -.2м
- Хүдрийн биет дотор хоосон чулуулгийн хамгийн их зузаан -4м

8. Зохиогчид Далан-Ухаа төмрийн хүдрийн ордод 2022-2023 онд гүйцэтгэсэн хайгуул ажлын үр дүнгээр ордын исэлдсэн хүдрийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 30,256.58 тн хүдэрт 25.41%-ийн дундаж агуулгатай 7,688.2 тн төмөр, боломжтой (С) зэрэглэлээр 30.33%-ийн дундаж агуулгатай 225,945.8 тн хүдэрт 68,519.4 тн төмөр, нийт исэлдсэн төмрийн нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 256,202.38 тн хүдэрт 29.75%-ийн дундаж агуулгатай 76,207.6 тн төмөр, анхдагч хүдрийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 30.24%-ийн дундаж агуулгатай 31,000.82 тн хүдэрт 9,374.65 тн төмөр, боломжтой (С) зэрэглэлээр 397,846.42 тн хүдэрт 31.73%-ийн дундаж агуулгатай 126,254.32 тн төмөр, нийт анхдагч хүдрийн нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 428,847.24 тн хүдэрт 31.63%-ийн дундаж агуулгатай 135,628.97 тн төмөр, ордын нийт исэлдсэн ба анхдагч хүдрийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 61,257.4 тн хүдэрт 27.83% дундаж агуулгатай 17,062.85 тн төмөр, боломжтой (С) зэрэглэлээр 623,792.22 тн хүдэрт 31.03% дундаж агуулгатай 194,773.72 тн төмөр, нийт исэлдсэн, анхдагч хүдрийн нөөцийг

бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 685,049.62 тн хүдэрт 29.43%-ийн дундаж агуулгатай 211,836.57 тн-оор тооцоолжээ.

Шинжээч дээрх нөөцийн тооцоог хянаж, дахин тооцоод ордын нөөцийг зохиогчийн хувилбараар хүлээж авахыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд санал болгож, хуралдааны үед зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг зүйтэй гэж үзэв.

9. Судалгааны талбай нь хамгийн сүүлийн үеийн гидрогеологийн дүүрэгчлэлээр Монгол орны гидрогеологийн өмнөд системийн Дунд халхын өндөрлөгийн уулс хоорондын ай савын Чойрын хотгор болон Цагаан нүдэнгийн хотгорын хил болох Дарцаг толгойн (1284м) ус хагалбарын хэсэгт хамаарагдана. Судалгааны талбайд хээрийн судалгааны явцад хайгуулын цооногуудад газрын доорхи усны түвшинг хэмжих ажил хийгдсэн. Үүний үр дүнд Далан ухаа хайгуулын талбайн цооногуудад газрын доорхи ус илрээгүй болно. Өөрөөр хэлбэл энэ талбай дахь ан цавын уст бүрдэл нь газрын доорхи ус агуулж хуримтлуулахгүй зөвхөн дамжуулан өнгөрөөх үүрэг гүйцэтгэх онцлогтой юм. Ордын талбай орчимд 2 гүний худаг байх ба тэдгээр худагас усны дээж авахад гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн цэнгэг ус гарсан байна.

10. Далан-Ухаа төмрийн хүдрийн ордын XV-022087 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах нөөцөд тулгуурлан хийсэн урьдчилсан техник эдийн засгийн тооцоогоор 2 жилийн хугацаанд 287.7 мян.тн баяжмал гарган авах бөгөөд, борлуулалтын орлого 54.66 тэрбум төгрөг, байгаль орчин, хаалт, нөхөн сэргээлтийн зардалд 0.8тэрбум төгрөг, уурхайн үйлдвэрлэлийн зардал 43.19 тэрбум төгрөг, татварын дараах цэвэр орлого 10.17 тэрбум төгрөг тус тус байна. Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 0.66жил, дотоод өгөөжийн норм (IRR) нь 84.83% байгаа нь тухайн төсөл ашигтай харагдаж байна. Орд нь дэд бүтцийн хувьд тааламжтай бөгөөд уул геологийн нөхцөлийн хувьд хүндрэл багатай ил аргаар олборлоход эдийн засгийн хувьд тохиромжтой байна.

11. Цаашид орд жижиг хэмжээтэй маш нийлмэл тогтоцтой, ордын бүлэг үнэмшил муутай байх тул олборлолтын үед нөөц буурах, хүдрийн биетийн зузаан багтлахгүй байх эрсдэл өндөртэй, техник-эдийн засгийн үнэлгээг боловсруулахдаа байгаль орчны үнэлгээнүүд хийх, ТЭЗҮ-ийг эрх бүхий байгууллагаар үндэслэлтэй боловсруулах, ус ашиглах дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах ажлыг төлөвлөгөөний дагуу хийх, холбогдох хууль тогтоомж, ялангуяа Ашигт малтмалын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан заавар, журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.3 дахь заалт, холбогдох хуулийн заалтууд болон энэхүү дүгнэлтийг үндэслэн дараах шийдвэр гаргахыг Үндэсний геологийн алба (УГА)-ны даргад уламжлахаар шийдвэрлэв. Үүнд:

Нэг. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Далан-Ухаа төмрийн хүдрийн ордод 2022-2023 онд гүйцэтгэсэн хайгуул ажлын үр дүнгийн тайлан (Ордын нөөц 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар) дахь исэлдсэн хүдрийн нөөцийг бодитой (B) зэрэглэлээр 30,256.58 тн хүдэрт 25.41%-ийн дундаж агуулгатай 7,688.2 тн төмөр, боломжтой (C) зэрэглэлээр 30.33%-ийн дундаж агуулгатай 225,945.8 тн хүдэрт 68,519.4 тн төмөр, нийт исэлдсэн төмрийн нөөцийг бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 256,202.38 тн хүдэрт 29.75%-ийн дундаж агуулгатай 76,207.6 тн төмөр, анхдагч хүдрийн нөөцийг бодитой (B) зэрэглэлээр 30.24%-ийн дундаж агуулгатай 31,000.82 тн хүдэрт

ТУС 0210

9,374.65 тн төмөр, боломжтой (С) зэрэглэлээр 397,846.42 тн хүдэрт 31.73%-ийн дундаж агуулгатай 126,254.32 тн төмөр, нийт анхдагч хүдрийн нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 428,847.24 тн хүдэрт 31.63%-ийн дундаж агуулгатай 135,628.97 тн төмөр, ордын нийт исэлдсэн ба анхдагч хүдрийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 61,257.4 тн хүдэрт 27.83% дундаж агуулгатай 17,062.85 тн төмөр, боломжтой (С) зэрэглэлээр 623,792.22 тн хүдэрт 31.03% дундаж агуулгатай 194,773.72 тн төмөр, нийт исэлдсэн, анхдагч хүдрийн нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 685,049.62 тн хүдэрт 29.43%-ийн дундаж агуулгатай 211,836.57 тн төмрийн нөөцийг энэхүү дүгнэлтийн хавсралт дахь хүснэгтийн дагуу хүлээн авах.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан төмрийн геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг УГА-ны Гео-мэдээллийн төв (Ц.Минжинсор)-д зөвшөөрөх.

Гурав. Энэхүү дүгнэлтийн 11-т заасан зүйлийг цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Ундармал хүдэр” ХХК (Э.Содболд)-д анхааруулах.

Дөрөв. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, дискийг ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүнийг үндэслэн гаргасан УГА-ны даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг “Ундармал хүдэр” ХХК (Э.Содболд)-д даалгах.

Тав. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Далан-Ухаа төмрийн хүдрийн ордын 2022-2023 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан боловсруулалтыг мэргэшсэн геологич С.Мөнхбаяр, геологич Л.Лхагвасүрэн, Н.Наран-Эрдэнэ, Б.Амгаланбаатар, Б.Даваадорж, Б.Энхтайван, геологийн зураглалын ажлыг “Азар Мэргэд” ХХК, ерөмдлөгийн ажлыг “Агшай зоос” ХХК, “Монгоулд дриллинг” ХХК, лабораторийн шинжилгээг “Трү Ти Ар Си” ХХК, “Эс Жи Эс-Ай Эм Эм И Монголиа” ХХК, “Ханлаб” ХХК, 1:2000-ны масштабын байр зүйн зураглалын ажлыг “Мэжор сүрвэй” ХХК, Палеонтологийн судалгааны ажлыг ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Д.Доржнамжаа, ЭШ-ний ажилтан Б.Энхбаатар, Д.Идэрсайхан нар, Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг Монгол Улсын Их Сургуулийн Антропологи Археологийн тэнхимийн профессор З.Батсайхан, эрдэм шинжилгээний ажилтан А.Золжаргал нар, геофизикийн судалгааны ажлыг “Азар Мэргэд” ХХК, “Аячук” ХХК, тайлан, түүн дэх ордын нөөцийн тооцоонд гаргасан шинжээчийн дүгнэлтийг МУ-ын зөвлөх геологич С.Алтангэрэл, хайгуулын ажлын үнэн бодит байдлыг “Ундармал хүдэр” ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ОРЛОГЧ ДАРГА

М.МЭНДБАЯР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР
ХУРАЛДААНЫ ДАРГА

Х.САНЧИГДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.СОЁЛМАА



ЭБМЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны
 ХК-01-03 дугаар дүгнэлтийн хавсралт



Далан-Ухаа төмрийн хүдрийн ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт
 (Ордын нөөц 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар)

